

**НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГА ДОРЖСҮРЭНГИЙН ОТГОНБААТАРЫН
2018 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН
БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ИЛТГЭХ ХУУДАС**

НЭГ.ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт

1.1.Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх-)-ний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 34 нийт арга хэмжээ (энэхүү загварын 1.2-т дурдсан тусгай арга хэмжээ орохгүй)-г хэрэгжүүлэх 51 үе шатны ажлын хэрэгжилтийг ажил тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 1

Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо	Хэрэгжүүлэх үе шатны ажлын тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1	2	3	4
34	51	0-30	

1.2.Гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон 14 /Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд 1.1.1.3, 2.1.2, 2.5.1, 2.5.13, 2.5.15, 2.5.16, 2.5.17, 2.5.18, 2.5.19, 2.5.20, 2.5.21, 4.1.8 заалтын нийт 34 үе шатны ажлын хэрэгжилтийг ажил тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 2

Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо	Хэрэгжүүлэх үе шатны ажлын тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1	2	3	4
14	34	0-40	

1.3. Манлайллын зорилт (орц) бүрийн биелэлтийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 3

Манлайллын зорилт (орц)-ын тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1	2	3
5	0-30	

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт /өөрийгөө хөгжүүлэх/-ын биелэлт:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 10 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлийн 2017 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн гаргасан Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 10-ны Б/55 захирамжаар Тээврийн газрын даргаар томилогдон ажиллаж байна.

1.5. Тухайн төсвийн шууд захирагчийн төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажилласан тухай дүгнэлт:

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 10, 14а-д заасны дагуу тус газрын зохион байгуулалтын нэгжийн дарга, Орлогч даргын орон тоог төрийн жинхэнэ албан хаагчдаас албан тушаал дэвшүүлэх замаар нөхөх саналыг Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэв. Хүргүүлсэн саналын дагуу 04, 05 дугаар саруудад сонгон шалгаруулалт хийгдэж доорх төрийн жинхэнэ албан хаагчдыг удирдах албан тушаалд томилов.

Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтаар Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд шалгарсан Э.Баяртыг Б/45, Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтсийн даргын албан тушаалд Д.Галбадрахыг Б/44, Тээврийн хяналтын хэлтсийн даргад Ц.Мягмарыг Б/62, Тээврийн логистикийн хэлтсийн даргад Г.Баасанг Б/63, Орлогч даргад Х.Булгааг Б/61 дүгээр тушаалаар тус тус томилсон. Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтаар Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн даргад М.Мөнхбаяр Б/133, Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд шалгарсан Б.Эрдэнболд Б/135, Тээврийн хяналтын хэлтсийн даргад З.Цэвээндорж Б/134, Орлогч даргад Ц.Мягмарыг Б/132 дүгээр тушаалаар тус тус томилсон.

Тус газарт байгаа төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлуулахаар Нийслэлийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/340 тоот албан бичиг хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн сайтад сонгон шалгаруулалтын зар тавигдсан бөгөөд 04 дүгээр сарын 10-ны өдөр бүртгэл явагдсан.

Тус газрын Эдийн засаг, судалгааны мэргэжилтэн ажлаас гарсан, Салбарын сургалт хариуцсан мэргэжилтэн тэтгэвэрт гарсан шалтгаанаар 2 сул орон тоо гарсан тул Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/340 тоот албан бичгээр Төрийн албаны мэргэшлийн шалгалт зарлуулах хүсэлтээ хүргүүлсэн. Төрийн албаны тухай хуулийн дагуу нөөцөд бүртгэгдсэн иргэдээс нөхөн бүрдүүлэлт хийхээр зарласан боловч тухайн 2 ажлын байрны шаардлагыг хангах иргэн байгаагүй болно. Иймд 04 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс Төрийн албаны мэргэшлийн шалгалт зарласан. Шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авч шалгарсан Д.Мөнхсарнайг Б/60 тушаалаар Салбарын сургалт хариуцсан мэргэжилтнээр, Э.Энхзулыг Б/58 дугаар тушаалаар Эдийн засаг судалгааны мэргэжилтнээр тус тус томилов.

Тус газрын Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Дотоод ажил, гадаад харилцаа, хуралдаан хариуцсан мэргэжилтний 1 сул орон тоо гарсан тул Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 05 дугаар сарын 29-ний өдрийн 1/708 тоот албан бичгээр иргэн Ц.Базаррагчааг нэр дэвшүүлсэн хүсэлт хүргүүлсэн. Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 06 дугаар сарын 05-ны өдрийн 14/258 тоот албан бичгээр тус албан тушаалд иргэн Ц.Базаррагчааг томилохыг зөвшөөрсөн тул 06 дугаар сарын 07-ны өдрийн Б/71 дүгээр тушаалаар томилов.

Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 10 дугаар сарын 12-ны өдрийн 14/384 тоот албан бичгээр тус газрын Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний 1 сул орон тоонд ажиллах иргэн Т.Оюунсүрэнг томилохыг зөвшөөрсөн тул 10 дугаар сарын 19-ний өдрийн Б/129 дүгээр тушаалаар томилов.

Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 12 дугаар сарын 11-ний өдрийн 14/445 тоот албан бичгээр тус газрын Тээврийн хяналтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагчийн 2 сул орон тоонд иргэн О.Сүхбаатар, Б.Мөнхзул нарыг томилохыг зөвшөөрсөн тул 12 дугаар сарын 18-ны өдөр О.Сүхбаатарыг Б/157, Б.Мөнхзулыг Б/158 дугаар тушаалаар тус тус томилсон.

- Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт, төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэхээр 2015-2019 оны сургалтын төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт:

Тайлант хугацаанд тус газарт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол 3, Нийслэлийн Засаг даргын захирамж 23, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 7, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал 1, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн зөвлөмж 1, Нийслэлийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоол 5 тус тус ирсэн.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Гэрээний биелэлтийн үнэлгээ

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 4

Гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1. Нийт арга хэмжээ (гарц)-ний биелэлт	0-30	
2. Тусгай арга хэмжээ(гарц)-ний биелэлт	0-40	
3. Манлайллын зорилт (орц)-ын биелэлт	0-30	
Нийт оноо	0-100	

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээгээ

гэж тэмдэглэнэ.

Хүснэгт 5

"А" буюу "Маш сайн"	"В" буюу "Сайн"	"С" буюу "Хангалттай"	"D" буюу "Дутагдалтай"	"F" буюу "Хангалтгүй"
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хэрэв "А" буюу "Маш сайн", эсхүл "D" буюу "Дутагдалтай", "F" буюу "Хангалтгүй" гэсэн үнэлгээ өгсөн бол энэ тухай үндэслэлээ бичнэ:

.....

4. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1).....

.....

2).....

.....Г.М.

5. Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт:

5.1. Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД НИЙСЛЭЛИЙН
 ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН
 БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН

.....

(огноо)

5.2. Үнэлгээтэй танилцсан:

Төсвийн шууд захирагч

НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГА ДОРЖСҮРЭНГИЙН ОТГОНБААТАР

.....

(огноо)

**“НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР”-ЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2018 он)**

НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Д/Д	Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)	Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ
1. Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх чиглэлээр / 2.5.3			
1.1	1.1.1 Нийслэлийн Тээврийн газрын даргын тушаалаар дүрэм, журам, бусад шийдвэрийг баталгаажуулан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.	Тайлант хугацаанд газрын даргын “А” тушаал 89, “Б” тушаал 148 нийт 237 тушаал гарч, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Газрын даргын 2018 онд баталсан 89 “А” тушаалд 73 кодификаци хийж, архивын шаардлага хангуулан тэмдэг тэмдэглэгээ хийн баталгаажуулсан. Нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн сан болох http://www.ublegal.mn/ сайтад газрын даргын 89 “А” тушаал, түүний хавсралтын хамт бүртгэв.	
2. Орлогч дарга болон хэлтсийн дарга, албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах /2.5.4			
2.1	2.1.1 Орлогч дарга болон хэлтсийн дарга, албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах “Үр дүнгийн гэрээ”-г 2018 оны 02 дугаар сарын 05-нд батлуулж, гэрээний хавсралт болох байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг 85 үе шаттайгаар боловсруулж, хяналт тавин ажиллаж байна. Төсвийн шууд захирагч 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр менежерүүдтэй 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулж баталгаажуулсан. 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Төрийн жинхэнэ албан хаагчдын 2018 оны үр дүнгийн гэрээг 53 албан хаагчтай мөн шинээр томилогдсон төрийн үйлчилгээний 6 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Жилийн эцсийн байдлаар 52 төрийн захиргааны албан хаагчийн үр дүнгийн гэрээг, 33 төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг дүгнэсэн. Үүнээс 4 албан хаагч	

		хангалттай буюу “С” үнэлгээ авсан тул “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу шаарлагатай сургалтад хамруулахаар санал гарган ажиллаж байна.	
3. Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн салбарын дунд болон хэтийн зорилт, стратегийн хүрээнд хэрэгжилтийг хангах, иргэдийн зорчих эрэлт, хэрэгцээг тодорхойлж, үр ашигтай сүлжээ бий болгон хөгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах. / 3.1.2			
3.1	3.1.1 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйлчилгээний цаг рейсын нэгдсэн даалгаврыг сар бүр боловсруулан батлуулна.	Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын шугамын цаг, рейсийн нэгдсэн даалгаврыг сар бүр боловсруулан холбогдох алба хэлтэс, "Улаанбаатар Смарт карт" ХХК-д цаасан хэлбэрээр батлуулан өгч ажилласан. Жилийн эцсийн байдлаар 45 удаа нэгдсэн даалгаварт өөрчлөлт орсон байна. Ажлын гүйцэтгэлд батлагдсан нэгдсэн даалгаврын хүрээнд сар тутам хяналт тавин ажиллаж байна.	
	3.1.2 Шинээр нийтийн тээврийн үйлчилгээ хүрсэн болон өөрчлөлт орсон чиглэлүүдэд сэтгэл ханамжийн судалгааг хийж, дүгнэлт гарган танилцуулна.	<p>1.2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Нийтийн тээврийн үйлчилгээний ШҮ:1 “5 шар - Ботаник” чиглэлээр зорчигч 51 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан бөгөөд иргэдийн хувьд тухайн чиглэлд маш сэтгэл ханамжтай байсан. Цаашид тухайн чиглэлийг тогтмол явуулж хэвшүүлэх талаар санал хүсэлт ихээр гаргасан.</p> <p>2.Зуны улирал эхэлж иргэдийн орой, үдшийн цагаар зорчих эрэлтийг хангах зорилгоор ШҮ:1 чиглэл дээр нэмж хотын төвөөс урагшаа ШҮ:2 “МУБИС-Нисэх”, хотын төвөөс хойшоо буюу ШҮ:3 “МУБИС-7 буудал-Зунжин худалдааны төв” чиглэлүүдийн үйлчилгээг шинээр төлөвлөж, шөнийн 02:00 цаг хүртэл явах зохицуулалтыг хийж 06 дугаар сарын 15-ны өдрөөс үйлчилгээг эхлүүлж 09 дүгээр сарын 17-ны өдрөөс ШҮ:2, ШҮ:3 зогсоож, ШҮ:1 иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>3.Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:62 чиглэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан сэтгэл ханамжийн судалгаа авч, санал дүгнэлт гарган танилцуулсан. Тус чиглэлд хийгдсэн эрэлтийн судалгаанаас харахад иргэд шинэ болон хуучин төлөвлөлтөд ойролцоо тооны сэтгэл ханамжтай байгаа нь харагдсан.</p> <p>4.Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:41, Ч:46 чиглэлүүдэд аж ахуй нэгж байгууллага солигдсонтой холбогдуулан сэтгэл ханамжийн судалгаа авч, санал дүгнэлт гарган 2018 оны 04 дүгээр сарын 24-ий өдрийн Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулсан. Мөн Сутайн буянт ХХК, НЧБ ХХК-тай уулзалт хийж, үйлчилгээний талаар болон сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн дүнг танилцуулсан.</p> <p>5. Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:27 чиглэлд зорчигч иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Иргэд тухайн чиглэлийн үйлчилгээг сайжруулж, техникийн бүрэн бүтэн байдлыг ханган шинээр өөр чиглэл нэмэх сонирхолтой байсан</p> <p>6. Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:11 "Хужирбулан-Офицеруудын ордон" чиглэлд зорчигчдоос сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгааны дүгнэлтэд зорчигчдын 75 хувь нь нийтийн тээврийн үйлчилгээний “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын Ч:11 “Хужирбулан – Ботаник – Офицеруудын ордон” чиглэлийн автобусны цэвэрлэгээ, үйлчилгээ, жолоочийн зан харилцаа, автобусны цагийн хуваарь мөрдөлт, маршрутаараа явдаг эсэхэд дунд болон муу гэсэн үнэлгээг өгч, маш удаан явдаг, оройн цагаар явдаггүй, жолооч нар байнга утсаар</p>	

		<p>ярьдаг зэрэг санал хүсэлт гаргасан. Иймд дээрх чиглэлийн үйлчилгээнд анхаарч ажиллах шаардлагатай байгаа талаар холбогдох судалгааны үр дүнг нэгтгэн Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т тус газрын 2/810 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>	
	<p>3.1.3 Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс эрэлтийн судалгааг хийж, дүгнэлт санал боловсруулна.</p>	<p>1. Ч:41 " Баруун салаа-Их тойруу-Халдвартын эмнэлэг" чиглэлд эрэлтийн судалгаа хийж тус чиглэлийн гаралтын тоо 10 байгаа хэдий ч 11, 14, 18 гаралттай чиглэлүүдтэй ойролцоо орлого олж байгаа тул автобус хоорондын интервалыг багасгаж гаралтын тоог 2-оор нэмэгдүүлж, автобус хоорондын интервалыг 8-9 минут болгож хүлээгдлийн хугацааг багасгах саналыг 01 дүгээр сарын 18-ны өдрийн Захиргааны зөвлөлийн хурлаар оруулсан боловч хөрөнгө шаардагдсан тул шийдвэрлэгдээгүй.</p> <p>2. Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:27 "Вокзал-Бөмбөгөр-Өвөр согоот" чиглэлд зорчигч урсгал болон эрэлтийн судалгааг хийсэн. СБД-ийн 17 дугаар хороо, "Сайхан ирээдүй" ХХК-тай хамтарсан судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд тухайн чиглэлийн тээврийн хэрэгслийн гаралтын тоог нэмэх шаардлагагүй. Одоо байгаа тээврийн хэрэгслийн тоо хангалттай гэж үзсэн.</p> <p>3. Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:62 "Алтан овоо 42-р гудамж /СХД 26-р хороо/ - Саппоро - 10-р хороолол" чиглэлийн замналд өөрчлөлт орсонтой холбогдуулан харьцуулсан судалгаа болон зорчигчдоос эрэлтийн судалгаа авсан. Тус чиглэлд өөрчлөлт орсны өмнөх үеийг өөрчлөлт орсны дараах мөн үетэй харьцуулахад ажлын 1 өдрийн дундаж зорчигчийн тоо өмнөх сараас 4,5 хувиар буурсан бол амралтын өдөр өмнөх сараас 11,1 хувиар буурсан байна. Мөн тус чиглэлд хийгдсэн эрэлтийн судалгаанаас харахад иргэд шинэ болон хуучин төлөвлөлтөд ойролцоо тооны сэтгэл ханамжтай байсан.</p> <p>4. Нийтийн тээврийн үйлчилгээний ШҮ:1 "5 шар - Ботаник" чиглэлээр зорчигч 51 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан бөгөөд иргэдийн хувьд тухайн чиглэлд сэтгэл ханамжтай байсан.</p>	
	<p>3.1.4 Нийтийн тээврийн чиглэлүүдийн зорчигч урсгалын төлөв байдлыг тогтоохоор шаардлагатай чиглэлүүдэд зорчигч урсгалын судалгааг хийж, дүгнэлт гарган танилцуулна.</p>	<p>1. ХО:5 "Налайх-Зүүн 4 зам-МУБИС" чиглэлийн цагийн хуваарийн мөрдөлт, ажлын гүйцэтгэл, зорчигч урсгалын судалгаа хийн нэгтгэн боловсруулсан. Судалгааны явцад гарсан зөрчлүүдийг нэг бүрчлэн баримтжуулан судалгааны дүгнэлтэнд оруулан урьдчилсан байдлаар танилцуулсан. Мөн тус чиглэлийн замналд өөрчлөлт оруулахаар санал боловсруулсан.</p> <p>2. 2017 онд шинээр хийгдсэн Хермес худалдааны төвийн автобусны зогсоолоор Ч:6 "Толгойт-Нарны зам-Ботаник" чиглэлийг дайран өнгөрүүлэхээр судалгааг хийсэн. Тус судалгаагаар 25-р эмийн сангийн зогсоолоор нийт зорчигчийн 10 орчим хувь нь үйлчлүүлж байгаа тул чиглэлд өөрчлөлт оруулах боломжгүй байна.</p> <p>3. Ч:62 "Алтан-Овоо-Саппоро-10-р хороолол" чиглэлд зорчигч урсгалын судалгаа хийж санал, дүгнэлт гарган танилцуулсан.</p> <p>4. Ч:40 "Алтан тариа - Улаанхуаран" чиглэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс тухайн чиглэлийн графикт өөрчлөлт оруулах талаар судалгааны тайланг боловсруулсан. "10-р хороолол" зогсоол дээр эрэлтийг судлах зорилгоор тухайн зогсоол дээрх зорчигчдын</p>	

		<p>ачааллын судалгааг хийсэн.</p> <p>5. 4:8 (Хайлааст - МУБИС - Цэцэг Төв), 4:40 (МахИмпекс - Тэнгис - Улаанхуаран), 4:42 (Сүлжмэл - Нарны Гүүр - Зайсан), 4:58 (3,4 хороолол - БММЗ), 4:59 (ХМК - Офицеруудын ордон) чиглэлүүдэд зорчигч урсгалын судалгааг хийсэн.</p> <p>6. Баянхошуунаас хотын төв рүү зорчих зорчигч урсгалын төлөв байдлыг тогтоохоор 4:20А "Баянхошуу - Геологийн төв лаборатори", 4:41 "Баруун салаа - Халдварт", 4:43 "Баянхошуу - ТЭЦЗ", 4:48 "Зүүн салаа - МУБИС" чиглэлүүдийн зорчигч урсгалын судалгааны тайланг боловсруулсан. "25-р эмийн сан" зогсоол дээр зорчигчдын ачааллын судалгааг хийж, дүгнэлт гарган танилцуулсан.</p>	
<p>4. Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах; / 3.1.3</p>			
4.1	<p>4.1.1 Автотээврийн тухай хууль түүнтэй нийцүүлэн боловсруулж байгаа дүрэм, журам, стандартуудад саналаа оруулна.</p>	<p>1. 01 дүгээр сарын 09-ний өдөр ЗТХЯ-ны сайдын 06 дугаар тушаалаар байгуулагдсан “ЗТХЯ-ны сайд болон НЗД нарын 2016-2020 онд Зам тээврийн салбарт хамтарч ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2018-2020 онд хамтарч ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулах” ажлын хэсгийн хуралд оролцож, "Санамж бичиг"-т оруулах өөрчлөлтөнд өгөх саналыг 01 дүгээр сарын 18-ны өдөр ЗАА болон ЗТХЯ-нд тус тус хүргүүлсэн. Ажлын хэсгийг ЗТХЯ-аас Цогтбаяр дэд сайд, НЗД-ын орлогч нар ахалж 05 дугаар сард Санамж бичигт өөрчлөлт оруулж баталсан.</p> <p>2.Тортогжилтыг шүүгч DPF төхөөрөмжийг суурилуулахтай холбоотой стандартын төсөлтэй танилцаж санал өгсөн.</p> <p>3.Зам, тээврийн салбарын стандартчиллын техникийн хороодын 2018-2019 оны ажлын төлөвлөгөөний төсөлд тус газраас тусгуулах саналыг ЗТХЯ-нд 2/13 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>4.ЗТХЯ-аас “Автотээврийн салбарт олон улсын стандарт нутагшуулах, үндэсний стандарт боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил” 266/2017 хэлэлцүүлэгт оролцсон.</p> <p>5.ЗТХЯ-аас 07/1452 тоот албан бичгээр ирүүлсэн “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар тэмдэг, 2 дугаар хэсэг. Ерөнхий шаардлага.” MNS 4410-2:2017 стандартад оруулсан саналыг дэмжиж 05 дугаар сарын 01-ний өдрийн 2/553 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.</p> <p>6.НАЗХГ-аас боловсруулж буй " Автозам сэтгэлгээ, орц гарц гаргах ажлын хэсэг"-ийн ажиллах журамд тус газрын зүгээс шаардлагатай мэдээллээр ханган санал тусгуулсан.</p> <p>7.Шинээр батлагдах автомашины жишиг нормд тусгуулах санал болон Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын судалгааг гаргаж 2-р сарын 13-ны өдрийн 2/232 тоот албан бичгээр ЗТХЯ-д хүргүүлсэн.</p> <p>8.05 дугаар сарын 08-ний өдрийн 1/609 тоот албан бичгээр “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг нийслэлд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах санал,</p> <p>9.05 дугаар сарын 25-ны өдрийн 1/691 тоот албан бичгээр Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж Замын хөдөлгөөний дүрмийн төсөлд тусгах саналаа НЗДТГ-т,</p> <p>10.Зам, тээврийн хөгжлийн яамнаас боловсруулсан “Автотээврийн тухай” хуулийн</p>	

		шинэчилсэн найруулга, Автотээврийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төсөлд оруулах холбогдох саналыг боловсруулж тус тус хүргүүлсэн. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг нийслэлд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах санал, Замын хөдөлгөөний дүрмийн төсөлд тусгах саналыг тус тус хүргүүлсэн.	
4.1.2	Нийтийн тээврээр үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр зорчих тухай холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах саналаа хүргүүлэх, үйлчилгээний хөлс төлөлтийг боловсронгуй болгоно.	АТТХ-ийн шинэчлэх саналд асуудлаар санал өгсөн. 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр НТЭГ, Монголын улаан загалмайн нийгэмлэг болон “Улаанбаатар смарт карт” ХХК-тай байгуулах гэрээний төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч гэрээнд тусган, №02/218 тоот гэрээг байгуулсан 2018 оны төсөвт 298, 2019 оны төсөвт 307 “Хүндэт донор” иргэнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тээвэрлэхээр тусгагдсан.	
4.1.3	Нийтийн тээврийн үйлчилгээнд цахим төлбөрийн систем нэвтрүүлэх болон ашиглахтай холбогдсон дүрэм, журмыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулна.	НИТХ-ын 2015 оны 6/22 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх журам”-д өөрчлөлт оруулах, судалгаа хийж, санал боловсруулах ажлын хэсэг Газрын даргын 2018 оны А/02 дугаар болон Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/51 дүгээр тушаалуудаар байгуулагдан 05 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хотын Ерөнхий менежерт, мөн газрын Захиргааны зөвлөлийн 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралд тус тус танилцуулсан. НТЭГ-ын Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу төслийг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдсэн. НИТХ-ын 2015 оны 6/22 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх журам"-ын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэх, хуваарилах, төлбөр тооцооны үйл ажиллагаа болон хариуцлагын зохицуулалтыг шинэчлэн боловсруулж, мөн журмын 4.4-д заасны дагуу инфляцийн түвшин, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан нэг машин цагийн зардалд өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох тооцоо судалгаа, танилцуулгыг боловсруулж нийслэлийн Засаг даргад 09 дүгээр сарын 12-ны өдрийн 1/1170, 11 дүгээр сарын 23-ны өдрийн 1/1473 албан бичгүүдээр НИТХуралд өргөн барьж шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн.	
5. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд дэвшилтэт технологи, тээврийн төрлийг нэвтрүүлэх, тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх / 3.1.4			
5.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих боломжийг сайжруулахын тулд нийтийн тээврийн автобусны, тохижилтын ажил хийгдсэн зогсоолд зарлагч төхөөрөмжийг холбогдох байгууллагуудтай хамтарч хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, суурилуулах ажлыг зохион байгуулна. Автобусанд	1. Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүд доторх буудал зарлах үйлчилгээг чанаржуулах зорилгоор буудал зарлах төхөөрөмжийг спикерт шууд холбох, програмын шинэчлэлт хийх ажлыг "Улаанбаатар Смарт карт" ХХК хариуцаж хийсэн. Уг ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 22 байгууллагын 1200 тээврийн хэрэгсэлд цахилгааны утас сольж, програмын шинэчлэлт хийгдээд байна. Програмын шинэчлэлт хийгдснээс хойш дээрх үйлчилгээтэй холбоотой санал, гомдол, техникийн ашиглалтын засвар үйлчилгээний дуудлага буурсан. 2. Улаанбаатар смарт карт ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүдэд	

	<p>буудал зогсоол зарлах дуут системийн ажиллагаанд хяналт тавьж ажиллана.</p>	<p>автобусны зогсоолыг иргэдэд зарлах Монгол инженерийн зохион бүтээсэн "Зогсоол зарлах" төхөөрөмжийг 2017 оны 09 дүгээр сард суурилуулж 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр бүрэн дуусгасан. Энэхүү ажлыг гүйцэтгэгч "ЭХО МН" ХХК нь алдаа дутагдлыг арилгах, сайжруулалтыг 2 удаа хийж гүйцэтгэсэн бөгөөд 10 дугаар сараас нийтийн тээврийн хэрэгслүүдэд суурилуулсан зогсоол зарлах төхөөрөмжийг дахин авч засварлаж, шуугих, тасалдаж зарлах, ажиллахгүй байгаа асуудлыг арилгах зорилгоор төлөвлөгөө гарган арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>3. 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдөр нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүд доторх буудал зарлах төхөөрөмжийн ажиллагааг шалгаж засварласан нийт 1113 тээврийн хэрэгсэл шалгаснаас 126 автобусанд уг төхөөрөмжийг суурилуулаагүй болон холболт хийгээгүй, 78 тээврийн хэрэгслийн төхөөрөмж ажиллахгүй байсан ба 31 тээврийн хэрэгсэл засварт орсон байсан.</p> <p>4. Автобусны зогсоолын нэрийг автобусны дотор талд хоолойгоор зарлах төхөөрөмжийг дахин засварлан одоогийн байдлаар 19 аж ахуйн нэгж, байгууллагаас "Сутайн буянт" ХХК болон "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазын бүх тээврийн хэрэгслүүдэд бүрэн дэлгэцээр зарладаг болсон. Үйлчилгээ үзүүлж буй автобусны дотор талд байрласан дэлгэцээр автобусны зогсоол болон бусад мэдээллийг авч, шуурхай засварлан хэвийн ажиллагаанд оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>5. "Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн систем"-д холбогдсон нийтийн тээврийн үйлчилгээний 1194 автобусны дотор талд байрлуулсан лэд самбараар автобусны зогсоол болон үйлчилгээний талаарх 2 төрлийн мэдээллийг, 212 автобусанд байрлуулсан лэд дэлгэцээр Арт импекс ХХК, Хотын хэмнэл ХХК-тай хамтран бусад мэдээллийг хүргэж байна.</p> <p>6. Улаанбаатар смарт карт ХХК-ийн зүгээс үйлчилгээний цэгийг Хүннү Молл-ын автобусны зогсоолд 2018 оны 03 дугаар сарын 24, "5 шар"-ын автобусны зогсоолууд дээр 5 дугаар сарын 10-нд, Офицеруудын ордон-ы автобусны зогсоолд 10 дугаар сарын 02-ны өдөр тус тус нээж үйл ажиллагааг жигдрүүлэн иргэдэд үйлчилгээг үзүүлж байна. Улаанбаатар смарт карт ХХК-ийн зүгээс Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүсэлт гаргасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/266 дугаар тушаалаар "U-Money" карт борлуулах цэнэглэх цэгийг нийт 124 байршилд байгуулахаар компанийн зүгээс бэлтгэл ажлыг эхлүүлж, цахим дэлгэц (техникийн үзүүлэлт: P3.9 нягтралтай, 1020 HD, 220 V, дэлгэцийн хэмжээ 1024x512, RGB) бүхий байгууламжийг 45 цэгт байршуулсан байна.</p>	
	<p>5.2 Өндөр хөгжилтэй орнуудын инновацийн үйл ажиллагаа, арга туршлагатай танилцах, судлах, Монгол орны нөхцөлд тохируулан байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх боломжийг судална.</p>	<p>1. Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлөөс 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 2/140 дугаартай албан бичгээр Монгол улсад үйлдвэрлэсэн МОН-30 загварын их багтаамжийн цахилгаан автобусаар Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажилд оролцох хүсэлтийг ирүүлсэн. Тус газар нь Автотээврийн тухайн хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.18 дугаар заалтын хэрэгжилтийг хангах үндсэн чиглэлийн хүрээнд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй стандартын шаардлага бүрэн хангасан нийтийн тээврийн хэрэгслээр иргэдэд үйлчлэх зорилгоор парк шинэчлэлтээр худалдан авах автобусанд дээрх шаардлагыг</p>	

		<p>хангасан байхыг гол шалгуур үзүүлэлт болгон ажиллаж байна. Иймд тус зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийг судалж МОН-30 загварын их багтаамжийн цахилгаан автобусны үйлдвэрлэлтэй холбоотой нэмэлт мэдээллийг авахаар 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2/568 дугаар албан бичгийг хүргүүлээд байна.</p> <p>2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсээс 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 07/1679 дугаар албан бичгээр Зам тээврийн хөгжлийн яамнаас боловсруулсан “Туршилт судалгаа хийх тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар ирүүлсэн. 05 дугаар сарын 02-ны өдөр Засгийн газрын 122 дугаар “Нийслэлийн нийтийн тээвэрт байгаль орчинд ээлтэй, цахилгаан автобус нэвтрүүлэх туршилт хийх тухай” тогтоол батлагдсан. 06 дугаар сарын 07-ны өдөр “Мон-30 загварын их багтаамжийн цахилгаан автобус нийлүүлэх, турших гэрээнд өгөх санал”-ыг НЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнд өгсөн.</p> <p>3. 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан Япон улсын Токио хотод дизель хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгслийг зохицуулсан журам хэрэгжүүлсэн талаар танилцуулах семинарт оролцсон.</p> <p>4. Монгол Улсын Засгийн газрын “Нийслэлийн нийтийн тээвэрт байгаль орчинд ээлтэй, цахилгаан автобус нэвтрүүлэх туршилт хийх тухай” 2018 оны 122 дугаар тогтоолоор “Монгол машин индустрал” ХХК нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглах “МОН-30Ц” загварын их багтаамжийн 2 ширхэг цахилгаан автобусыг үйлдвэрлэж, ашиглалтад хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 317 дугаар тушаалаар уг тээврийн хэрэгслүүдийг хүлээн авах, нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх талаар туршилт, судалгааны ажил хийх техникийн комиссууд байгуулагдан ажиллаж эхлээд байна.</p>	
<p>6. Тээврийн үйлчилгээтэй холбогдсон дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч, үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоож, мэдээллийн сан бүрдүүлэх. 3.1.7</p>			
6.1	<p>6.1.1 Зам, тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам"-уудыг хэрэгжүүлнэ.</p>	<p>Зам, тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам"-уудыг хэрэгжүүлэн жилийн эцсийн байдлаар нийслэлд авто үйлчилгээ эрхлэж буй нийт 71 буюу 46 аж ахуйн нэгж, байгууллага, 25 иргэний үйл ажиллагаанд ангилал тогтоож гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс А ангилал-2, В ангилал- 35, С ангилал- 34</p>	
	<p>6.1.2 Авто үйлчилгээний байгууллагын мэдээллийн сангийн программыг ашиглах ажлыг эхлүүлж, нэгдсэн бүртгэлтэй болно.</p>	<p>НТЭГ-ын даргын 2017 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн програм хангамж боловсруулах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан 3 удаа хуралдсан. НТГ 17/01 болон "Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сангийн програм хангамж нийлүүлэх", НТГ 17/02 дугаартай зөвлөх үйлчилгээг "Кредо терра" ХХК гүйцэтгэхээр ирүүлсэн техникийн саналыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь заалтыг үндэслэн хянан үзэж, шаардлагад нийцээгүй тул санхүүгийн саналыг нээлгүй буцаасан. Уг тендерт "Төрийн болон орон нутгийн өмчийн</p>	

		<p>хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь заалтыг үндэслэн "Аствишн" ХХК-ийн ирүүлсэн санхүүгийн саналыг 04 дүгээр сарын 03-ны өдрийн 09 цаг 45 минутад нээсэн. 04 дүгээр сарын 19-ний өдөр "ЕС" зөвшөөрлийн хяналт, удирдлагын системийн програм хангамжийн нэмэлт хөгжүүлэлт болон "Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн програм хангамж боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг "Аствишн" ХХК-тай байгуулсан. Үүнтэй холбогдуулан тус 2 програм хангамжийн ажлын гүйцэтгэл, явцыг дүгнэх, хүлээн авах ажлын хэсэг байгуулах газрын даргын тушаалын төсөлд санал авч байна.</p> <p>Мөн авто үйлчилгээний байгууллагын мэдээллийн сангийн програмыг ашиглах ажлыг эхлүүлж, нэгдсэн бүртгэлтэй болгох ажлын хүрээнд Нийслэлийн хэмжээнд авто засвар, сэлбэг худалдаа эрхлэгч нийт 242, үүнээс 144 иргэн, 98 аж ахуйн нэгж, байгууллага, томоохон техникийн худалдаа эрхлэгч "Өгөөмөр" техникийн зах, "Да хүрээ" техникийн зах болон авто худалдааны ажил үйлчилгээ эрхлэгчдийг хамруулсан судалгааг батлагдсан удирдамжийн дагуу 05 дугаар сарын 15-ны өдрөөс 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийсэн.</p> <p>Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай 145 авто үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлсэн бөгөөд үүнээс аж ахуйн нэгж байгууллага 54, иргэн 71 байна. Автотээврийн үндэсний төвийн avtobox.mn сайтад нийт 125 иргэн аж ахуйн нэгжийг мэдээллийн сангийн програмд нэгтгэн бүртгээд байна.</p>	
	<p>6.1.3 Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалтыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.</p>	<p>БЗД-ийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн 3 дугаар хэлтэс зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран 06 дугаар сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрийн хооронд тухайн дүүрэгт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг авто машин, техникийн сэлбэг хэрэгслийн худалдаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах шалгалтыг зохион байгуулж дуусаад байна. Шалгалт эхний 7 хоногийн байдлаар: авто худалдаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгж, авто засварын үйлчилгээ эрхэлдэг 4 аж ахуйн нэгж, 5 иргэний үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг өгсөн.</p> <p>НТЭГ-ын дарга, ХУД-ийн Засаг дарга нарын 05 дугаар сарын 01-ний өдөр хамтран баталсан "Авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад холбогдох хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтын удирдамж"-ийн хүрээнд батлагдсан хөтөлбөрийн дагуу ХУД-ийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд "Автотээврийн тухай", "Галын аюулгүй байдлын тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулиуд болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг сурталчлах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 05 дугаар сарын 02-ны өдөр ХУД-н ЗДТГ-ын хурлын танхимд сургалт зохион байгуулсан.</p> <p>08 дугаар сарын 03-ны өдөр "Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хийх хяналт шалгалтын удирдамж"-ийг боловсруулан батлуулсан. Үүний дагуу Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч 33 иргэн, 16 аж ахуйн нэгж байгууллага, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт</p>	

		<p>авто үйлчилгээ эрхлэгч 35 иргэн, 11 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу үзлэг шалгалтыг зохион байгуулан ажилласан. Үүнээс зөрчил дутагдал илэрсэн 29 иргэн, 12 аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлаа арилгах хугацаатай мэдэгдэл өгч ажилласан.</p> <p>Мөн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу тус дүүргийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газрын хяналтын улсын байцаагч, мэргэжлийн хяналтын хэлтэс, байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч болон Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн байцаагч нартай хамтран 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр авто машины кузов засвар эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай, Автотээврийн тухай, Зөрчлийн тухай, Эрүүл ахуйн тухай, Хог хаягдлын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Байгаль орчны багц хуулиудын холбогдох заалтууд, Авто үйлчилгээ-Ангилал, Ерөнхий шаардлага MNS5025:2010 стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлаа арилгах хугацаатай мэдэгдэл өгч ажилласан. Шалгалтаар 5 кузов засварын газар хамрагдсанаас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй, дүүрэгтэйгээ хамтын ажиллагааны гэрээ байгуулж бүртгүүлээгүй, ажлын байр нь хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал илрүүлэн ажилласан.</p> <p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүгийн 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр баталсан 1/228, 1/229 тоот “Чингэлтэй дүүрэг дэх гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэрэгжилт, инженерийн шугам сүлжээ, автотээвэр, авто зам, барилга байгууламжийн чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Мэргэжлийн Хяналтын ерөнхий газрын Автотээврийн хяналтын улсын ахлах байцаагч ахалж, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Автотээврийн хяналтын улсын ахлах байцаагч, Нийслэлийн Тээврийн газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэйгээр 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар зөрчилтэй авто үйлчилгээ эрхэлж байгаа 2 аж ахуйн нэгж, байгууллагыг 2.0 сая, 14 иргэнийг 700.0 мянган төгрөгөөр арга хэмжээ тооцсон.</p>	
<p>7. Тээвэр, логистикийн талаарх дүрэм, журмын төсөл боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, үр ашигтай сүлжээ бий болгон хөгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах / 3.1.8</p>			
7.1	7.1.1 Улаанбаатар хотын нэгдсэн логистик төвийг улсын хэмжээний логистик терминалуудтай авто зам, төмөр замаар холбох ажлын зураг төсөлд саналаа тусгаж мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	Нийслэл хотын баруун хэсэгт худалдааны логистик төв байгуулах талаар хийсэн судалгаа болон "Номин холдинг" ХХК-ийн "Улаанбаатар импекс" агуулах худалдааны төвийн барилга, байгууламжийг түшиглэн ачаа тээврийн терминал байгуулах тухай танилцуулгыг ЗТХЯ болон НЗАА, НАЗХГ, НМХГ, ЗЦА, "ЗХУТ" ОНӨҮГ-т 01 дүгээр сарын 15-ны өдрийн 4/78 тоот албан бичгээр хүргүүлэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 03 дугаар сарын 01-ний өдөр ЗТХ-ийн Сайд Ж.Бат-Эрдэнэтэй ЗТХЯ-ны АТБХЗГ-ын дарга С.Батболд, тус газрын орлогч дарга холбогдох мэргэжилтнүүдийн хамт уулзаж, "УБ хотын баруун, зүүн хэсэгт	

		худалдаа, ачаа тээврийн терминал байгуулах тухай" танилцуулсан. Улаанбаатар хотын баруун бүсийн "Хангарди" олон улс, хот хоорондын автобус терминал, олон улсын худалдаа логистикийн төвийн барилгын шав тавих ёслол Авто худалдааны цогцолборт 10 дугаар сарын 11-ний өдөр болсон. Олон улсын худалдааны логистикийн төв нь нийт 24 автобусны гарцтай, 4200 ам метр талбай байхаар төлөвлөсөн байна.	
	7.1.2 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын тээвэрлэлтийн тайлан болон "Улаанбаатар смарт карт" ХХК-ийн УМЦТС-ийн бүртгэл, тайланг үндэслэн чиглэл тус бүрийн орлогын доод хязгаарыг улирал тутам тогтооно.	1. Улаанбаатар смарт карт" ХХК-ийн удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн бүртгэл, тайланг үндэслэн 2018 оны 2 дугаар улирлын орлогын доод хязгаарын тооцооллыг хийж, төслийг боловсруулан 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулж холбогдох саналуудыг тусган өмнөх жилийн тухайн сарын ажил болон амралтын өдрийн тоо, дундаж орлого, даалгавар цаг, тээврийн хэрэгслийн тоо зэргийг харгалзан авч үзэн 2018 оны 2 дугаар улирлын чиглэл бүрийн орлогын доод хязгаарын төлөвлөгөөг батлуулсан. 2. 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн захиргааны зөвлөлийн хурлаар 2018 оны 03 дугаар улирлын орлогын доод хязгаарын төслийг 3 хувилбараар гарган танилцуулсан ба зорчигч урсгал орлогын өсөлт /бууралт/-ийн хэмжээг харгалзан үзэж Хувилбар 2-ыг сонгон батлав. 3. 2018 оны 04 дүгээр улирлын орлогын доод хязгаарын саналыг гарган танилцуулж 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр батлуулж аж ахуйн нэгж байгууллагуудад 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 2/1139, 2/1140, 2/1141 тоот албан бичгүүдээр хүргүүлэв. 1. 2018 оны 4 дүгээр сард 4.9 тэрбум төгрөг, 5 дугаар сард 5.1 тэрбум төгрөг, 6 дугаар сард 4.8 тэрбум төгрөгийн шугамын орлогыг төвлөрүүлэх төлөвлөгөө гарав. 2. 2018 оны 3 дугаар улиралд 7 дугаар сард 2,9 тэрбум төгрөг, 8 дугаар сард 3,7 тэрбум төгрөг, 9 дүгээр сард 4,1 тэрбум төгрөгийн шугамын орлогыг төвлөрүүлэх төлөвлөгөө гарав. 3. 2018 оны 10 дугаар сарын орлогын доод хязгаар 3.9 тэрбум, 11 дүгээр сарынх 3.4 тэрбум, 12 дугаар сарынх 3.1 тэрбум төгрөгөөр тус тус тогтоов.	
8. Нийтийн тээврийн эрэлт, хэрэгцээг хангуулах зорилгоор үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, сүлжээ төлөвлөлт, хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эдийн засгийн хэмнэлттэй шинэ төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх талаар тооцоо, судалгааг хийж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах. / 3.1.15			
8.1	8.1.1 Улаанбаатар хотын гудамж замаар нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхцалын судалгааг гаргаж, сүлжээ төлөвлөлтийг сайжруулж, холбогдох дүрэм, журам, захирамжийн хэрэгжилтийг хангуулах талаар санал боловсруулж танилцуулна.	Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхцалын судалгааг Их тойруу, Чингисийн өргөн чөлөө, Энхтайвны өргөн чөлөө дагуух зогсоолуудаар гарган нэгтгэсэн. Дээрх судалгааны дүнг холбогдох төлөвлөлтийн ажилд ашиглаж гудамж замаарх чиглэлийн давхардлыг бууруулахаар 3 чиглэлийг богиносгон үйлчилгээг эхлүүлээд байна. Мөн судалгааны материалыг ашиглан 1 дүгээр эгнээний захирамжийн хэрэгжилтийг хангуулах талаар санал боловсруулан танилцуулга бэлтгэн 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүүд танилцуулсан.	
	8.1.2 Салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийг гарган холбогдох газарт хүргүүлэх, нэгдсэн	Нийслэлийн зорчигч тээврийн салбарын 2017 оны 4 дүгээр улирлын Техник эдийн засгийн үзүүлэлтийг гарган 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр нийслэлийн Статистикийн газар болон Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.	

	<p>системд оруулах ажлыг хамтран хэрэгжүүлнэ.</p>	<p>2018 оны 1 дүгээр улирлын Техник эдийн засгийн үзүүлэлтийг гарган 04 дүгээр сарын 05-ны өдрийн 2/421, 2/422 тоот албан бичгээр нийслэлийн Статистикийн газар болон Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж нэгдсэн системд оруулсан.</p> <p>07 дугаар сарын 05-ны өдрийн 2/906, 2/907 тоот албан бичгээр 02 дугаар улирлын Техник эдийн засгийн үзүүлэлтийг Нийслэлийн Статистикийн газар болон Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>03 дугаар улирлын Техник эдийн засгийн үзүүлэлтийг гарган холбогдох байгууллагуудад тус газрын 10 дугаар сарын 08-ны өдрийн 2/1266, 2/1267 тоот албан бичгүүдээр хүргүүлэв.</p>	
<p>9. Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, өргөжүүлэх, мэдээллийн программ хангамжийг сайжруулах, төлбөр төлөх системд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах. /3.1.17</p>			
<p>9.1</p>	<p>9.1.1 “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</p>	<p>НТЭГ-ын Нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг Улаанбаатар смарт карт ХХК нь “Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системээр хэрхэн тооцож байгааг туршин танилцах удирдамж”-ийг батлан програм хөгжүүлэлтийн алдаа зөрчлийг илрүүлэх, илэрсэн алдааг засварлуулах, цаашид системээс гарч буй мэдээ, тайлангийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Ч:59 “ХМК-Офицеруудын ордон” чиглэлд туршилтын ажлыг зохион байгуулж нийтийн тээврийн үйлчилгээний батлагдсан цагийн хуваарь, чиглэл, ажлын гүйцэтгэлийг хэрхэн тооцож байгааг баримтжуулан, илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар хамтран ажилласан.</p> <p>02 дугаар сарын 08-ны өдрийн 2/064 тоот албан бичгээр “Улаанбаатар смарт карт ХХК-ийн 2018 оны төлөвлөгөө” ирүүлсэн. Төлөвлөгөөтэй танилцан шаардлагатай ажлуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>НЗДТГ-т төслийг хэрэгжүүлэгч Улаанбаатар смарт карт ХХК-иас төслийн хэрэгжилт хэт удаашралтай байгаатай холбоотойгоор 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 3/188 дугаартай албан бичгээр хандсан. 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 3/1096 дугаартай албан бичгээр “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх ажлын хүрээнд дэд системүүдэд тавигдах ерөнхий шаардлагын биелэлтийг хангасан эсэх талаар судалгаа”-г хүргүүлсэн.</p> <p>НЗДТГ-т төслийг хэрэгжүүлэгч Улаанбаатар смарт карт ХХК-ийн өнөөгийн үйл ажиллагаатай танилцан, Нийслэлийн Засаг дарга болон төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан “Дата карт консорциум”-хооронд 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гэрээ”-ний үүргийн биелэлтийг дүгнэх, ажлын хэсэг шинэчлэн байгуулах хүсэлтийг хүргүүлэн, ажлын хэсэг байгуулах захирамжийн төсөл боловсруулан ажиллаж байна.</p>	

10 Нийтийн тээврийн автобус болон бусад тээврийн хэрэгслийн зогсоолуудын талбайн хэмжээг тогтооход холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, зогсоолын мэдээллийн нэгдсэн санг үүсгэх. / 3.1.18

10.1	10.1.1 Нийтийн тээврийн зогсоолын мэдээллийн сан үүсгэн баяжилт хийнэ.	01 дүгээр сарын 25-ны өдрийн А/08 тоот тушаалаар Санктпетербург зогсоолын нэршлийг Сүхбаатарын талбай, Хятад худалдааны төв зогсоолын нэршлийг Баянзүрх их дэлгүүр, Ионсей эмнэлэг зогсоолын нэршлийг Өргөө амаржих газар, цагдаагийн академи зогсоолын нэршлийг Хууль сахиулах их сургууль болгон өөрчилж google earth болон visio програмд оруулсан. Мөн толгойтын замд шинээр “Толгойт 1” зогсоол нэмэгдсэн бөгөөд 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/31 тоот тушаалын дагуу google earth болон visio програмд нэмж оруулсан. ХУД-ийн 10, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 7 дугаар сургуулийн /баруун/ болон /зүүн/ автобусны зогсоолуудыг авто замын засварын үеэр 50м шилжүүлсэн. 2018 онд нийт 25 зогсоол шинээр нэмэгдэж 43 чиглэлд, мөн 8 зогсоолын нэршилд өөрчлөлт орж давхардсан тоогоор 57 чиглэлд өөрчлөлт орсон байна.	
	10.1.2 Нийтийн тээврийн зогсоолуудыг кадастрын зурагт оруулах ажлыг зохион байгуулна.	Нийслэлийн нутаг дэвсгэр дэх газрын улсын бүртгэлд бүртгэгдээгүй, газар эзэмших эрх олгогдоогүй нийт 47 эцсийн зогсоолын кадастрыг байгууллагын өөрийн хөрөнгөөр кадастрын зургийг тус газраас геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр кадастрын зургийг шинээр хийлгэн баталгаажуулаад 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 2/1280 тоот албан бичгийг нийслэлийн Газрын албанд хүргүүлэн ажилласан.	

11. Нийтийн тээврийн ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд болон холбогдох бусад байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээ дүгнэх, сонгон шалгаруулах, гэрээ зөрчсөн байгууллагуудын гэрээг цуцлах арга хэмжээ авах, гэрээнд өөрчлөлт оруулах талаар саналаа гаргах./ 3.1.20

11.1	11.1.1 Нийтийн тээврийн ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд болон холбогдох бусад байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээ дүгнэх, сонгон шалгаруулах, гэрээ зөрчсөн байгууллагуудын гэрээг цуцлах арга хэмжээ авах, гэрээнд өөрчлөлт оруулах талаар саналаа гаргах.	Эхний 11 сарын байдлаар: 1. Үндсэн чиглэлийн үйлчилгээний 19 аж ахуйн нэгж, байгууллагуудын гэрээний үүргийн биелэлтийг сар бүрийн 5-ны өдрөөс 10-ны өдрүүдэд дүгнэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаагүй ААНБ-д торгууль тавьж ажилласан. Үүнд: - 1 сард - 4 ААНБ-д - 1.955.866 төгрөг, - 2 сард - 13 ААНБ-д – 9.450.133 төгрөг, - 3 сард - 13 ААНБ-д – 8.203.933 төгрөг, - 4 сард - 17 ААНБ-д – 9.966.933 төгрөг, - 5 сард - 14 ААНБ-д- 4.090.865 төгрөг, - 6 сард – 10 ААНБ-д – 3.451.533 төгрөг, - 7 сард - 14 ААНБ-д - 4.649.060 төгрөг, - 8 сард -13 ААНБ-д – 5.131.000 төгрөг, - 9 сард -15 ААНБ-д – 8.643.580 төгрөг, - 10 сард -16 ААНБ-д - 8.612.650 төгрөг, - 11 сард - 18 ААНБ-д - 14.046.560 төгрөг нийт өссөн дүнгээр 78.202.113 төгрөгийн	
------	--	---	--

		<p>гэрээний торгууль ногдуулсан байна.</p> <p>2. Туслах үйлчилгээ эрхлэн гүйцэтгэдэг 5 аж ахуйн нэгж, байгууллагуудаас "Өндөр буянт трейд" ХХК бүртгэлийн санд хөдлөх бүрэлдэхүүнгүй болсон тул 10 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон гэрээ цуцлах мэдэгдлийг 1/1208 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>3. Буухиа үйлчилгээний 2 аж ахуйн нэгж, байгууллагуудаас Бичил аян эздийн хоршооны гэрээ 05 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болж дууссан тул НЗД-ын 2017 оны А/431 дүгээр захирамжийн дагуу үүрэг тус бүрээр дүгнэж, "Хангалтгүй" үнэлэгдсэнээр цаашид сунгах боломжгүй болсон.</p>	
<p>12. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд шалгаж дүгнэлт гаргах, түвшин тогтоох, аттестатчилал, сонгон шалгаруулалт явуулах ажлыг зохион байгуулах./ 3.1.22</p>			
12.1	<p>12.1.1 Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, цагийн хуваарь мөрдөлт, баримт бичгийн бүрдэл, гэрээний үүргийн биелэлт, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад хяналт тавих, хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>Нийслэлийн тээврийн салбарт сахилга хариуцлагыг дээшлүүлэх, захиргааны хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр 2018 оны байдлаар Автотээврийн хяналтын 20 улсын байцаагч ажиллаж, 2018 онд шалгалтад 183 хуулийн этгээд, 66465 иргэн хамрагдсанаас, 47802 тээврийн хэрэгсэл шалгагдаж, 1276 зөрчил илрүүлж, "Зөрчлийн тухай" хуулийн дагуу 1276 зөрчилд 50220.0 мянган төгрөгийг шийтгэлийн хуудсаар захиргааны арга хэмжээ ногдуулж улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний 20 аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор 54 удаа 147 заалттай, ерөнхий боловсролын 18 сургуульд 93 заалттай, 47 авто үйлчилгээ, авто засварын газарт 178 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч, 903 заалт бүхий техникийн дүгнэлт 207 гаргасан байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 99 аж ахуйн нэгж, байгууллагад хийхэд 353 заалт биелэгдэн 96.2 хувьтай дүгнэгдсэн автотээврийн хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны дүгнэлт гаргаж ажилласан байна.</p>	
<p>13. Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд шалгаж, дүгнэлт гаргах, ангилал тогтоох ажлыг зохион байгуулах/ 3.1.23</p>			
13.1	<p>13.1.1 Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоолгосон байгууллага, иргэдтэй гэрээ байгуулан ажиллах, Тээвэрлэлтийн баримт бичгийн бүрдүүлэлтэд хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчилд арга хэмжээ тооцно.</p>	<p>Тус газрын даргын 2015 оны А/47 дугаар тушаалын дагуу авто үйлчилгээний ангилал тогтоолгосон байгууллага, иргэдийн үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд шалгаж, дүгнэлт гарган Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дээр авто үйлчилгээ эрхлэгч иргэд ААНБ-ын үйл ажиллагаа нь стандартын шаардлагыг хангаж буй эсэхэд үзлэг хийж БГД-ийн Засаг даргын дэргэдэх "Зөвлөл"-д 22, ХУД-ийн Засаг даргын дэргэдэх "Зөвлөл"-д 3, Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх "Зөвлөл"-д 25, Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх "Зөвлөл"-д 7, Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх "Зөвлөл"-д 20, Сонгино хайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх "Зөвлөл"-д 4 буюу нийт 81 саналын хуудас тус тус хүргүүлэн заавар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Зам, тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам"-уудыг хэрэгжүүлэн жилийн эцсийн байдлаар нийслэлд авто үйлчилгээ эрхлэж буй нийт 71 буюу 46 аж ахуйн нэгж, байгууллага, 25 иргэний үйл ажиллагаанд ангилал тогтоож гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс А ангилал-2, В ангилал- 35, С ангилал- 34.</p> <p>Дараах хяналт, шалгалтын ажлуудыг хийсэн байна. Үүнд: Нийслэлийн нутаг дэвсгэрт авто</p>	

		<p>үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хийх хяналт шалгалтын ажлын удирдамжийг 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдөр батлуулан, үүний дагуу Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч 33 иргэн, 16 аж ахуйн нэгж байгууллага, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч 35 иргэн, 11 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу үзлэг шалгалтыг зохион байгуулан ажилласан. Зөрчил дутагдал илэрсэн 29 иргэн, 12 аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлаа арилгах хугацаатай мэдэгдэл өгсөн.</p> <p>Мөн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу тус дүүргийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газрын хяналтын улсын байцаагч, мэргэжлийн хяналтын хэлтэс, байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч болон Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн байцаагч нартай хамтран 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр авто машины кузов засвар эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай, Автотээврийн тухай, Зөрчлийн тухай, Эрүүл ахуйн тухай, Хог хаягдлын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Байгаль орчны багц хуулиудын холбогдох заалтууд, Авто үйлчилгээ-Ангилал, Ерөнхий шаардлага MNS5025:2010 стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлаа арилгах хугацаатай мэдэгдэл өгч ажилласан. Шалгалтаар 5 кузов засварын газар хамрагдсанаас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй, дүүрэгтэйгээ хамтын ажиллагааны гэрээ байгуулж бүртгүүлээгүй, ажлын байр нь хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал илрүүлэн ажилласан.</p>	
<p>14. Иргэдэд төрөөс үзүүлж байгаа нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг зохион байгуулалттайгаар тасалдуулах, хууль бусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох. / 3.1.24</p>			
14.1	14.1.1 Хууль бусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.	<p>НТГ, ЗЦАлбаны дарга нарын хамтран баталсан “Гэрээ, хэлцэлгүйгээр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг хууль бусаар эрхлэгчдэд хяналт, шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу БГД, БЗД, ХУД, ЧД, СБДүүргийн ЗЦАлбатай хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажилласан. НТГазартай “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх, гүйцэтгүүлэх” /буухиа үйлчилгээ/ 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 3/002 тоот гэрээтэй ажилладаг “Бичил аян” эздийн хоршоотой хамтарсан шалгалтаар 241 тээврийн хэрэгсэл хамрагдаж, зураг авалт хийж, зөрчилтэй 35 жолоочийн бичиг баримтыг хураан авч, 18 жолоочид “Зөрчлийн тухай хууль”-ийн 14.6 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасны дагуу тус бүрийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон шийтгэл оногдуулж, 17 жолоочид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.</p> <p>Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн албан хаагчидтай хамтран тээвэрлэлтийн гэрээгүйгээр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн тээврийн хэрэгслийн жолооч нарт хяналт тавьж, шалгалт хийлээ. Тээвэрлэлтийн гэрээгүйгээр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн 11 тээврийн хэрэгслийн жолооч нарын бичиг баримт ирүүлж, “Зөрчлийн тухай” хуулийн 14.6-р зүйлийн 12 дахь хэсэгт заасан “Тээвэрлэлтийн</p>	

		<p>гэрээгүй нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн” заалтын дагуу тус бүр нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нийт 1100.0 мянган төгрөгийн арга хэмжээ тооцож ажиллалаа.</p> <p>Гэрээ хэлцэлгүйгээр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдэд хяналт шалгалт хийх чиглэлээр 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд ХУД, БГД, БЗД-ийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран ажилласан. Мөн орлогч дарга Х.Булгаагийн баталсан 2018 оны 07 дугаар сарын 17, 27-ны өдрийн “Чингис хаан” олон улсын нисэх буудалд хууль бус такси үйлчилгээ эрхлэгчдэд хяналт тавих шалгалтын удирдамжийн дагуу 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн "Чингис хаан" Олон улсын нисэх буудалд хууль бус такси үйлчилгээ эрхлэгчдэд хяналт тавих шалгалтын удирдамж"-ийн дагуу Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран ажиллаж зөрчил гаргасан 2 жолоочид Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9 дэх заалтад заасны дагуу тус бүр 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийтгэл оногдуулсан.</p>	
<p>15. Нийтийн тээврийн үйлчилгээний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, соёлд тавих хяналт шалгалтын чиглэлээр төрийн бус байгууллага болон иргэний төлөөлөлтэй хамтарч ажиллах / 3.1.25</p>			
15.1	<p>15.1.1 Холбогдох мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах стандартын шаардлага, гэрээний үүргийн биелэлт, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх зорилго бүхий болзолт уралдааныг 2018 оны 02 дугаар сараас 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулна.</p>	<p>Нийслэлийн өдрийг угтан нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад тавигдах стандартын шаардлага, гэрээний үүргийн биелэлт, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх зорилго бүхий болзолт уралдааныг 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 12 дугаар сарын 14-ний өдрийн хооронд зохион байгууллаа.</p> <p>Тус уралдааныг Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хороолол хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү, НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, нийслэлийн Тээврийн газар, Тээврийн цагдаагийн албаны нийслэлийн Замын хөдөлгөөний хяналтын газар, Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨҮГ, “Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг”, “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо” ТББ, “Том оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн холбоо” ТББ, “Таксийн үйлчилгээ эрхлэгчдийн холбоо” ТББ, “Улаанбаатар Смарт карт” ХХК-уудын төлөөллүүд хамтран дүгнэсэн юм.</p> <p>Тус уралдааны дүнгийн хурал 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдөр “Улаанбаатар чуулга”-д зохион байгуулж салбарын шилдгүүдээ шалгарууллаа. Тэргүүн байрыг “Зорчигч Тээвэр Гурав” ОНӨААТҮГ, II байрыг “Сутайн буянт” ХХК, III байрыг “Мяралзаа” ХХК, Тусгай байрыг “Эс Энд Эй” ХХК, “Эрдэм транс” ХХК тус тус эзэлсэн юм.</p> <p>Такси үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагуудаас “ВИП такси сервис” ХХК Тэргүүн байр, “ТЭБЭ сервис” ХХК II байранд шалгарч бусад аж ахуй нэгж байгууллагуудаа манлайллаа.</p> <p>Мөн тус дүнгийн хурлын үеэр Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр нийтийн тээврийн салбарт амжилттай ажиллаж байгаа 3 жолооч, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр 2 жолооч, “Хүндэт тэмдэг”-ээр 1 жолооч, Зам, тээврийн хөгжлийн яамны “Онц тээвэрчин” цол тэмдэгээр 1 жолоочийг тус тус шагнасан юм.</p>	

16. Нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээ, шаардлагатай бусад тооцоо, судалгааг нийслэлийн өмчийн оролцоотой "Улаанбаатар смарт карт" ХХК болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч бусад аж ахуй нэгж байгууллагаас гаргуулан авах / 3.1.26

16.1	16.1.1 Улаанбаатар смарт карт ХХК-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайланг үндэслэн тухайн сарын орлого, нийт машин цагийн зардлын зөрүүг тооцож НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ.	<p>"Улаанбаатар смарт карт" ХХК-ны ирүүлсэн мэдээгээр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд эхний 10 сарын өссөн дүнгээр:</p> <ul style="list-style-type: none"> - Нэгдүгээр сард - 6,023.3 сая төгрөг, - Хоёрдугаар сард – 5,311.9 сая төгрөг, - Гуравдугаар сард – 4,927.1 сая төгрөг, - Дөрөвдүгээр сард – 3,517.1 сая төгрөг, - Тавдугаар сард – 4,497.9 сая төгрөг, - Зургаадугаар сард – 4,491.7 сая төгрөг, - Долоодугаар сард – 5,562.1 сая төгрөг, - Наймдугаар сард – 5,254.4 сая төгрөг, - Есдүгээр сард – 4,595.2 сая төгрөг, - Аравдугаар сард - 4,795.3 сая төгрөг, - Арваннэгдүгээр сард - 4,750.3 сая төгрөг, - Арванхоёрдугаар сард - 5,335.9 сая төгрөг <p>Нийт – 59,027.4 сая төгрөгийн зардлын санхүүжилт олгох тооцоолол гарч, нийт 57,915.6 сая төгрөгний санхүүжилт олгоод байна.</p>	
	16.1.2 Нийслэлийн тээврийн газар нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний машин цагийн зардалд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн үйлчилгээний даалгавар цагийг үндэслэн тооцоолж, 2018 оны нийслэлийн төсвийн тодотгол болон 2019 оны нийслэлийн төсөвт тусгуулах саналаа НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ.	<p>Байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн тайланг гарган НЗДТГ-ын СТСХэлтэст хугацаанд нь хүргүүлсэн болно.</p> <p>Тус газрын 2019 оны нийслэлийн төсөвт тусгах саналыг боловсруулж 2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 1/1055 дугаар албан бичгийг НЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>МУЗГ-ын шийдвэрийн дагуу 2018 оны нийслэлийн төсөвт тодотгол хийгээгүй.</p>	

17. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах / 3.1.28

17.1	17.1.1 Автобусны зогсоолд удаан хугацаагаар зогссон суудлын автомашины зөрчлийг ЗХУТөв шилжүүлж, хууль бусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.	<p>Автотээврийн хяналтын улсын байцаагч нар нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолуудад дүрэм зөрчин зогсож байгаа зөрчлийг таслан зогсоох, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нийтийн тээврийн хэрэгслийн хурдан шуурхай зорчих нөхцөлийг бүрдүүлэх, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт, шалгалтыг тогтмол явуулж байна. Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд автомашин байршуулж саад учруулсан 1105 жолоочийн зөрчлийг Замын хөдөлгөөний удирдлагын төвд шилжүүлж, шаардлага хангаагүй буюу баталгаажих боломжгүй нийт 264 зөрчлийн фото зураг хасагдаж, баталгаажсан 841 тээврийн хэрэгсэлд 16820.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна.</p>	
	17.1.2 Нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлж байгаа зорчигчдын карт	<p>2018 оны 4 дүгээр улирлын байдлаар 5 удаа хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.</p> <p>03 дугаар сарын 29-ний өдөр НТЭГ, УБСКарт ХХК, Сити баз консалтинг ХХКомпанийн дарга</p>	

	ашиглалтын явцад шалгалт хийж, зөрчлийг арилгах, арга хэмжээ авч ажиллана.	нарын хамтран баталсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний их болон дунд багтаамжийн автобус, троллейбусны өнгө үзэмж, зорчигчдын хөлс төлөлтийн байдалд хяналт тавих” удирдамжийн дагуу 04 дүгээр сарын 02-06, 16-20-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. 18 аж ахуйн нэгж, байгууллагын 48 чиглэлийн 482 тээврийн хэрэгсэл хамрагдаж 332 зөрчил илрүүлсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг байгууллагын удирдлагуудад танилцуулж цаашид гадна, дотор цэвэрлэгээнд анхаарч ажиллах талаар танилцуулж, “Зөрчлийн тухай” хуулийн дагуу 10 жолоочид 250.0 мянган төгрөг, бэлэн мөнгө авсан 5 жолоочид “Зөрчлийн тухай” хуулийн 14.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасныг үндэслэн 125000 төгрөгийн арга хэмжээ тооцож, 325 зорчигчийг газар дээр нь картыг нь цэнэглүүлж зөрчлийг арилгуулсан. Мөн 09 дүгээр сарын 10-14-ний өдрийг дуустал 190 хүний бүрэлдэхүүнтэйгээр шалгалт хийж бэлэн мөнгөний зөрчилтэй 8110 зорчигчийг тээврийн хэрэгсэлд нэвтрүүлэхгүйгээр ЗӨВХӨН КАРТ-аар зорчих зөвлөмж мэдээллээр хангаж “Зорчигчийн товхимол” 6965 ширхэг, “Санамж” хуудас 6521 ширхэгийг тарааж, 5516 зорчигчийг карт цэнэглэх цэгээр үйлчлүүлж ажиллалаа. Энэхүү шалгалтын хүрээнд “Автобусанд бэлэн мөнгөөр зорчсон иргэдэд сануулга өгч, ажиллаж байна” “Нийтийн тээврээр үйлчлүүлж буй иргэдийн бэлэн мөнгөөр зорчих зөрчил багасч байна”, “Зорчигчид 24 цагаар ажилладаг Circle K, CU сүлжээ дэлгүүрүүдээр картаа цэнэглүүлээрэй” зэрэг мэдээ болон тодруулгыг Zaluu.com, News.mn, Gogo.mn, Arslan.mn гэх тэргүүтэй 20 өдөр тутмын веб сайт, “Өнөөдөр”, “Монголын мэдээ” сонинууд болон “Star”, “TV-9” телевизүүдээр дамжуулан олон нийтэд мэдээллийг хүргэсэн.	
18	18.1 Байгууллагын 2017 оны жилийн эцэс, 2018 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан гаргах, шинжилгээ хийх, дүгнэлт гарган даргын зөвлөлд танилцуулах.	Байгууллагын 2017 оны жилийн эцсийн тайлан болон 2018 оны I, II, III улирлын санхүүгийн тайлан гарган НЗДТГ-ын СТСХэлтэст хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд санхүүгийн явцын аудит орж, дүгнэлт гарсан болно. Тус газрын 2019 оны нийслэлийн төсөвт тусгах саналыг боловсруулж 2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 1/1055 дугаар албан бичгийн хамт НЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.	
19	19.1 Байгууллагын 2018 оны баталсан төсөв болох 1.3 тэрбум төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зардлын ангиллаар захиран зарцуулж, хяналт тавьж ажиллана.	Энэ онд 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас хүлээгдэж буй гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны нийт зардал 1.200.089 тэрбум төгрөг. Үүнээс: - Цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд 914.848.000 төгрөг, - Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 110.259.000 төгрөг - Байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд 48.200.000 төгрөг, - Хангамж бараа материалын зардалд 60.674.000 төгрөг, - Норматив зардалд 3,014,910 төгрөг, - Эд хогшил худалдан авах зардалд 772,200 төгрөг, - Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 37.958,548 төгрөг, - Бараа үйлчилгээний бусад зардалд 24.363.000 төгрөгийн зардлыг тус тус хууль тогтоомжийн дагуу зардлын ангиллаар захиран зарцуулж, хяналт тавьж ажиллаж байна.	
20	20.1 Нийслэлийн 2018 оны батлагдсан төсвийн дагуу 100.0 сая төгрөг, төсөвт	НИТХ-ын 2017 оны 02/22 дугаар тогтоолын 2.1.1.16 дахь заалтад тус газар хүү торгуулийн орлого болох 100.000.000 төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр тусгасан бөгөөд	

	<p>байгууллагын өөрийн орлого 1033900.0 төгрөгийг тус тус Нийслэлийн төсөвт төвлөрүүлнэ.</p>	<p>автотээврийн хяналтын улсын байцаагчийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлогыг төвлөрүүлэх данс нээсэн.</p> <p>Иймд НТЭГ-аас автотээврийн хяналтын улсын байцаагчийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлогыг хэрхэн хаана төвлөрүүлэх талаар чиглэл авахаар 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/321 дүгээр албан бичгээр МХЕГ-т хүргүүлж, 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/924 дүгээр албан бичгээр “Улсын байцаагчдын тавьсан торгууль, шийтгэврийн орлогыг тухай бүр МХЕГ-ын хяналтын орлогын дансанд төвлөрүүлж ажиллах нь зүйтэй” гэх хариу ирсэн байна. Дээрх тайлбаруудыг 05 дугаар сарын 28-ны өдрийн 1/697 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн, шийдвэрийг хүлээж байна. Дээрх тайлбаруудыг 05 дугаар сарын 28-ны өдрийн 1/697 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргад МХЕГ-с 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 01/2276 тоот албан бичигт ирүүлсэн байна. Уг бичигт “Нийслэлийн тээврийн газартай байгуулсан гэрээнд 2019 оноос өөрчлөлт оруулан байцаагчийн зөрчилд ногдуулсан шийтгэлийн хуудасны зарцуулалтын тайлан, орлого төвлөрүүлэлтийг орон нутгийн төсөвт шилжүүлэх болно” гэж дурьдсан байна.</p> <p>Нийслэлийн төсөвт тусгагдсан төлөвлөгөөний дагуу тайлант онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 870,0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 163,9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажиллахаас үндсэн үйл ажиллагааны орлого 903,2 сая төгрөг туслах үйл ажиллагааны орлого 142,6 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 101.2 хувиар биелүүлсэн.</p>	
21	<p>21.1 Албан хэрэг хөтлөлтийн “Edoc” програмд газрын даргын тушаал болон гадны байгууллагаас ирсэн, явсан албан бичгийг цахим файл үүсгэн програмд оруулан бүртгэх болон Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвөөр ирсэн албан бичгийг газрын даргад шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах, Албан бичгийн барагдуулалтын судалгааг сар, улирал бүрийн өссөн дүнгээр хэлтэс бүрээр гарган хугацаа хоцорсон албан бичгийн мэдээ тайланг гарган холбогдох албан тушаалтан, удирдлагад танилцуулна.</p>	<p>Байгууллагад 01 дүгээр сарын 02-ноос 12 дугаар сарын 07-ны хооронд нийт 2737 албан бичиг ирснээс хариутай 1568 албан бичиг, хариугүй 1169 албан бичиг хүлээн авч газрын дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, хүлээлгэн өгч хяналт тавьж ажилласан. Хариутай албан бичгээс хугацаандаа шийдвэрлэсэн 1433, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 67, шийдвэрлээгүй 1, шийдвэрлэлтийн шатандаа 74, хугацаа сунгуулсан 13 албан бичиг байна.</p>	
22	<p>22.1 Архивын 2018 оны хөтлөх хэргийн жагсаалт, ББНШК-ийн 2018 оны төлөвлөгөө боловсруулж батлуулах. Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн мэдээллийг цахимаар хадгалах./</p>	<p>Байгууллагын 2018 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад:</p> <ul style="list-style-type: none"> - байнга хадгалах 55 хөтлөх хэрэг, - 70 жил хадгалах 4 хөтлөх хэрэг, - түр хадгалах 113 хөтлөх хэрэг буюу нийт 172 хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг нийслэлийн Архивын газрын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 06 	

	цахим архив үүсгэх/, архивын программ ашиглан газрын даргын 2017 оны тушаалуудыг шивж оруулах, архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэлт, архивт шилжүүлж буй хадгаламжийн нэгжүүдэд нягтлан шалгалт хийх. 2017 оны архивын баримтанд байнга, түр хадгалах, баримтын данс бүртгэл үйлдэх устгах бичгийн түүвэр жагсаалтыг гаргаж комиссын хурлаар хэлэлцүүлнэ.	дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар хурлаар батлуулсан. Байгууллагын 2017 оны нөхөн бүрдүүлэлтээр: - байнга хадгалах 44 хөтлөх хэрэг, - 70 жил хадгалах 6 хөтлөх хэрэг, - түр хадгалах 347 хөтлөх хэрэг, - зураг төслийн 4 хөтлөх хэрэг, - гэрэл зургийн 38 баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн бүртгэл үйлдэн, нөхөн бүрдүүлэлт хийсэн болно.	
23	23.1 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний үндсэн, хот орчмын, туслах, буухиа чиглэлийн өдөр тутмын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулж, зохицуулалт, бүртгэл хяналтын жигд ажиллагааг хангах, үйлчилгээний мэдээ мэдээллийг нэгтгэж танилцуулах, мэдээллийн бодит байдлыг хангахад хяналт тавьж ажиллана.	Үндсэн болон хот орчмын 87 чиглэлд 19 аж ахуйн нэгж, байгууллагын 941 угсраа, их, дунд багтаамжийн автобус, троллейбусаар өдөр тутмын нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна. • Үндсэн болон хот орчмын чиглэлд: Үндсэн болон хот орчмын 87 чиглэлд 21 аж ахуйн нэгж, байгууллагын 937 угсраа, их, дунд багтаамжийн автобус, троллейбусаар өдөр тутмын нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Нийт 282547 тээврийн хэрэгсэл ажиллахаас 282395 тээврийн хэрэгсэл буюу гүйцэтгэл 99.9 %, өдөр бүрийн цагийн гүйцэтгэлээр 3333672:34 цаг ажиллахаас 3170325:57 цаг ажиллаж 95.1 %, 2207156.5 рейс гүйцэтгэхээс 1842823.5 рейс ажиллаж 83.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. • Туслах чиглэлд: 5 аж ахуйн нэгж байгууллагын нийт 4146 тээврийн хэрэгсэл 56736:13 цаг ажиллахаас 4110 тээврийн хэрэгсэл 55851:21 цаг буюу 98.4 %-ийн гүйцэтгэлтэй, 202,569,000 төгрөгний орлоготой ажилласан. • Буухиа үйлчилгээнд: 2 аж ахуйн нэгжийн байгууллагын нийт 11881 тээврийн хэрэгсэл 101648:00 цаг ажиллахаас 94616:00 цаг буюу 93.1 %-ийн гүйцэтгэлтэй 678837200 төгрөгний орлоготой ажилласан. • Таксийн үйлчилгээнд: Такси үйлчилгээний 11 аж ахуйн нэгж байгууллагын 19252 тээврийн хэрэгсэл, 550653 цаг ажиллаж 992558770 төгрөгний орлоготой, нийт 528 удаа мэдээ өгөхөөс 285 удаа мэдээ өгсөн. Мэдээ өгөөгүй аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийг гэрээний мэргэжилтэнд тухай бүр гаргаж өгсөн. • Зам тээврийн осол, зөрчлийн тухай мэдээ: Өдөр бүр Тээврийн Цагдаагийн газраас мэдээ, мэдээллийг авч, удирдлагуудад танилцуулах, Автотээврийн хяналтын улсын байцаагчийг осол гарсан газарт ажиллуулж байна. Зам тээврийн осол, зөрчил 11 сарын байдлаар гэмтэж бэртсэн 82, эмнэлэгт хэвтсэн 13, нас барсан 4, нийт 121 зам тээврийн осол зөрчил гарсан мэдээлэлтэй байна.	
24	24.1 Шинэ жил, сар шинэ, улсын баяр наадам, зуслангийн, зам засварын ажил, зэрэг цаг үеийн нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөлтийн	1. Шинэ жилийн баярын үйлчилгээ: НТГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Шинэ жилийн баярын болон амралтын өдрүүдэд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах тухай” А/96 дугаар тушаалын дагуу 2017 оны 12 дугаар сарын 31, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүр гарч нийтийн тээврийн	

<p>дагуу зохион байгуулж хяналт тавин, мэдээ тайланг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллана.</p>	<p>үйлчилгээний бүртгэл, зохицуулалт, хяналт шалгалтын ажлыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Үндэсний тусгаар тогтнолын өдөр, Шинэ жилийн болон амралтын өдрүүдэд үндсэн болон хот орчмын 86 чиглэлд 21 аж ахуйн нэгж байгууллагын 3633 угсраа, их, дунд багтаамжийн автобус ажиллахаас 3630 тээврийн хэрэгсэл (99,9%), 44057:35 цаг (97 %) ажиллаж 1,585,630 зорчигч тээвэрлэсэн байна.</p> <p>12 дугаар сарын 31-ний өдрийн "Улаанбаатарын мөнгөн үдэш" шинэ жилийн цэнгүүний үед төлөвлөлтийн дагуу Д.Сүхбаатарын талбайн 3 цэгээс 18 чиглэлд 18 их багтаамжийн автобус иргэдэд үйлчилж, 765 зорчигч тээвэрлэсэн.</p> <p>2. Сар шинийн баярын үйлчилгээ: НТЭГ-ын даргын 02 дугаар сарын 09-ний өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу 02 дугаар сарын 16,17,18-ны өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүр томилогдож нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэл, зохицуулалт, хяналт шалгалтын ажлыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.</p> <p>НЗД-ын 2018 оны А/112 дугаар "Сар шинийн баярын өдрүүдэд нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" захирамжийн хүрээнд иргэдийг Сар шинийн баярын өдрүүдэд "Үнэ төлбөргүй" зорчуулж үндсэн 74, хот орчмын 13 чиглэл, нийт 87 чиглэлд 2082 угсраа, их, дунд багтаамжийн автобус, троллейбус 26186:00 цаг ажиллахаас 2082 тээврийн хэрэгсэл (100.0%), 25426:47 цаг (97.1%) ажилласан. Үүнээс Шөнийн тээврийн үйлчилгээнд 12 тээврийн хэрэгсэл 30:00 цаг ажиллахаас 100.0% гүйцэтгэлтэй ажилласан.</p> <p>3. Баярын өдрүүдэд ажилласан мэдээ, тайланг тухай бүрд НЗДТГ, ЗАА, Шуурхай удирдлагын төв, НОБГ-т тус тус хүргүүлж ажилласан.</p> <p>4. "Улаанбаатар марафон-2018" олон улсын гүйлтийн тэмцээний үеэр мөрдөх нийтийн тээврийн үйлчилгээний төлөвлөлтийг батлах тухай" А/36 дугаар тушаал гарч 05 дугаар сарын 19-ний өдөр 07:00-17:00 цагийн хооронд нийтийн тээврийн үйлчилгээний 39 чиглэлд өөрчлөлт орж төлөвлөлтийн дагуу ажиллуулсан.</p> <p>5. Зуслангийн үйлчилгээг 3 чиглэлд явуулахаар төлөвлөж, олон нийтэд мэдээллэн 06 дугаар сарын 15-ны өдрөөс үйлчилгээг эхлүүлж, 09 дүгээр сарын 17-ны өдрөөс зогсоосон.</p> <p>6. Нийслэлийн Засаг даргын 2018 оны "Автомашингүй өдөр зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/861 дүгээр захирамжийн дагуу нийслэлийн Тээврийн газрын даргын 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/78 тоот тушаалаар тус арга хэмжээний үеэр мөрдөх нийтийн тээврийн үйлчилгээний төлөвлөлтийг баталсан. 2018 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 08:00-17:00 цаг хүртэл замналд өөрчлөлт оруулсан. Тухайн өдрийн ажлын тайланг 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 1/1249 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>7. Улсын их баяр наадмын ажлын тайланг НЗДТГ-т 07 дугаар сарын 17-ны өдрийн 3/959, ЗАА-д 3/960 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>8. Нийслэлийн Тээврийн газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн "Даншиг наадам-Цам хүрээ" наадмын үед нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулж, хяналт тавих тухай А/58 дугаар тушаалын дагуу 08 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд нийтийн тээврийн</p>	
--	--	--

		үйлчилгээний бүртгэл, зохицуулалт, хяналт шалгалтын ажлыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэв.	
25	25.1 “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн бүртгэлийн сан”-гийн журмын дагуу шилжилт хөдөлгөөнийг хийж, удирдлагыг нэгдсэн мэдээллээр хангаж ажиллана.	<p>“Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд өөрчлөлт оруулах” журмыг шинэчлэн боловсруулж, газрын даргын 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар баталгаажуулсан.</p> <p>2018 оны 11 сарын байдлаар нийтийн тээврийн бүртгэлийн санд үндсэн чиглэлийн 19 аж ахуйн нэгж байгууллагын 1207 тээврийн хэрэгсэл, туслах шугамын 4 аж ахуйн нэгж байгууллагын 14, буухиа үйлчилгээний 1 аж ахуйн нэгж байгууллагын 10, такси үйлчилгээний 10 аж ахуйн нэгж байгууллагын 628 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.</p> <p>Морь барьдаг ХХК, Монкара ХХК-иуд Эрдэм транс ХХК-тай, НЧБ ХХК Трансбус ХХК-тай тус тус нэгдэж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай” 73 дугаар тогтоолоор “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ байгуулсантай холбогдуулан бүртгэлийн санд шилжилт хөдөлгөөнийг журмын дагуу шилжүүлэн бүртгэсэн.</p> <p>Бүртгэлийн сангаас 2018 оны эхнээс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд үндсэн чиглэл 149, такси үйлчилгээ 258 тээврийн хэрэгслээр нэмэгдсэн ба нийтдээ бүртгэлийн санд 408 тээврийн хэрэгсэл нэмж бүртгэж, насжилтаар 187, техник хяналтын үзлэгээр 232, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр 105, нийт 546 тээврийн хэрэгслийн хасалт хийсэн.</p>	
26	26.1 Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагуудын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, өвөлжилтийн бэлтгэл ажил хангалтын талаар “бүрэн бус хангалттай”, “хангалтгүй” үнэлгээ авсан ААН-эгжүүдэд гүйцэтгэлийн шалгалт хийнэ.	<p>Нийслэлийн нийтийн тээврийн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө”-г шинэчлэн батлуулсан.</p> <p>НТЭГ-ын 05 дугаар сарын 31-ний өдрийн 3/722 тоот албан бичгээр өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг ирүүлэх, төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүрийн 25-ны дотор ирүүлэхийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад үүрэг болгосон.</p> <p>Нийтийн тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах Ажлын хэсэгт холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/72 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд 09 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Удирдамжийн хүрээнд шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Тус газартай гэрээ байгуулан ажилладаг үндсэн чиглэлийн 20 ААНБ хамрагдахаас 19 ААНБ (Тэнүүн дэлгэр ХХК өөрийн байранд үйл ажиллагаа явуулаагүй байсан) буюу 95,0 хувь хамрагдсан. Ажлын хэсэг Өвөлжилтийн бэлтгэл ажлын хангалтанд 14 үзүүлэлтээр үнэлгээ өгсөн. Шалгалтад хамрагдсан үндсэн чиглэлийн 19 аж ахуйн нэгжүүдээс 6 ААН 91-ээс дээш оноо буюу “Бүрэн хангалттай”, 8 ААН 81-ээс 90 хүртэлх оноо буюу “хангалттай”, 4 ААН 71-аас 80 хүртэлх оноо буюу “бүрэн бус хангалттай”, 1 ААН 70-аас доош оноо буюу “хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн.</p> <p>Салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг тайланг гаргаж ЗТХЯ, Захирагчийн ажлын албанд тус тус албан бичгээр хүргүүлсэн.</p>	

27. Салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр

<p>27</p>	<p>27.1.1 Тээврийн салбарын сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулна. НЗДТГ-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран 14 хоног тутамд НТҮ-ний жолооч нарт сургалт зохион байгуулж ажиллана.</p>	<p>Тайлант хугацаанд сургалт хариуцсан мэргэжилтэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу нийт 9 удаагийн сургалт зохион байгуулсан байна. НЗДТГ-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран 14 хоног тутамд НТҮ-ний жолооч нарт дараах сургалтуудыг зохион байгуулж ажилласан. Үүнд: 03 дугаар сарын 05-наас 09-ний хооронд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 9 аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА 10 ажилтан хамрагдсан. 05 дугаар сарын 17-ны өдөр ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал унтраах тактик, галын аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ, болзошгүй гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах аврах мэдлэг, дадлыг олгох талаар, 05 сарын 24, 25-ны өдрүүдэд батлагдсан удирдамж, хуваарь, хөтөлбөрийн дагуу 6 удаагийн давталттайгаар Дэлхийн тамхигүй өдөр, Мансууралтай тэмцэх олон улсын өдрийг тохиолдуулан “Тамхигүй Улаанбаатар” хөтөлбөр, “Эрүүл залуус” аяны хүрээнд “Тамхи зүрхэнд хортой-Тамхи биш эрүүл мэндийг сонгоё” уриан дор Нийслэлийн эрүүл мэндийн газар, Наркологийн эмнэлэгтэй хамтран, “Гэр бүлийн боловсрол, үнэ цэнэ”, “Харилцаа хандлага, стресс менежмент” сэдвээр тус тус сургалтыг явуулав. 05 дугаар сарын 31-ний өдөр Нийслэлийн Замын хөдөлгөөн зохицуулах хэлтсээс ирүүлсэн 09 тоот албан мэдэгдлийн дагуу “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 2 дугаар баазын удирдлага, инженер техникийн ажилчид, жолооч нийт 120 хүнд “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн 2.3-а, 2 дугаар хавсралтад заасан зөрчил гаргуулахгүй байх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, чирэгч автомашинуудын байнгын бэлэн байдалд шуурхай ажиллуулах чиглэлээр сургалтуудыг тус тус явуулсан. Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Зам, тээврийн хөгжлийн яаманд 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 1536 тоот албан бичгээр ирүүлсэн Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар өгсөн чиглэлийн хүрээнд тус газраас зохион байгуулсан “Төмөр замын гарам, аюултай бүс” сэдэвт сургалт, зөвлөгөөнөөс зөвлөмж гарган Зам, Тээврийн хөгжлийн яам, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”, Замын цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Төмөр зам дахь цагдаагийн газар, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад хүргүүлсэн. Нийтийн тээврийн үйлчилгээний жолооч нарт 14 хоног тутам дүүргүүдийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль, эрх зүйн баримт бичгүүдийн талаар шаардлагатай мэдлэг, мэдээллээр хангах, хууль, дүрмийг чанд дагаж мөрдөн, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулсан. Тайлант хугацаанд сургалтанд 17 ААНБ-ын 250 гаруй жолооч хамрагдсан байна. 2018 онд сургалт хариуцсан мэргэжилтэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 17 сэдвээр 187 давталттай сургалт зохион</p>
-----------	--	--

		байгуулсан байна.	
28	28.1.1 Техникийн үзлэг, оношилгооны төв барих газрын асуудлыг холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлэх, барилгын баталгаажсан зураг төсөл хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.	Оношлогооны төв барих газрын асуудлыг холбогдох байгууллагуудтай уулзаж санал тавьж байгаа бөгөөд Авто худалдааны цогцолборт 2.5 га газрыг "Ашиглуулах гэрээ" байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн оношлогооны төвийг барих барилгын зураг байгаа болно. Холболтын зураг хийх ажлын тендерийг НХОГ-аас 2017 оны 10 дугаар сард зарлаж, шалгарсан компани нь холболтын зургийн ажил хийж байна. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийтийн тээврийн техникийн үзлэг, оношилгооны төвийн барилгын ажлыг эхлүүлэхээр 850.0 сая төгрөг тусгуулсан.	
29	29.1 2018 оны хавар болон намрын техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах, Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн техникийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд хяналтын үзлэг, оношилгоо явуулах, дүгнэлт гаргана.	<p>НТЭГ-ын даргын 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн "Хаврын техникийн үзлэг, оношилгоо зохион байгуулах" тухай А/18 дугаар тушаал батлагдан гарч 03 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд үндсэн чиглэлийн 1057, туслах чиглэлийн 10, буухиа чиглэлийн 71, такси үйлчилгээний 474, ажилчдын автобус 43 буюу нийт 1786 тээврийн хэрэгсэл хаврын үзлэг оношилгоонд орохоос 1655 тээврийн хэрэгсэлд буюу 92,6%-д техникийн үзлэг, оношилгоо хийж дүгнэлт гаргасан. Захиргааны зөвлөлийн 06 дугаар сарын 06-ны өдрийн 15 дугаар хурлын шийдвэрээр шалтгаангүйгээр оношлогоонд ороогүй 124 тээврийн хэрэгслийг бүртгэлийн сангаас хасахаар шийдвэрлэж, шийдвэрийг хэрэгжүүлсэн.</p> <p>НТЭГ-ын даргын 2018 оны "Намрын техникийн үзлэг, оношилгоо зохион байгуулах" тухай А/68 дугаар тушаалаар нийт 1888 тээврийн хэрэгслээс намрын техникийн үзлэгт орох 1882 тээврийн хэрэгсэл буюу 94,5% нь хамрагдсан.</p> <p>2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл тус газрын техникийн үзлэг, оношилгооны төв үндсэн чиглэлийн 1166, туслах чиглэлийн 9, буухиа чиглэлийн 8, таксийн үйлчилгээний 523, ажилчдын автобус 73 буюу нийт 1779 тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг, оношилгоо хийж дүгнэлт гаргасан байна.</p> <p>Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийтийн зорчигч тээврийн хэрэгслээс ялгарах утааны тортогжилтын хэмжээг явуулын оношилгооны багажаар хэмжих шалгалтыг шугам замд 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс хийж нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний 11 компанийн их багтаамжийн 107 автобус хамрагдсан бөгөөд утааны тортогжилтын хэмжээ стандарт үзүүлэлтээс их байсан зөрчлүүдэд Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.</p> <p>Агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Баянгол дүүргийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 117 тоот "Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайгаар зарим төрлийн автотээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцохыг хязгаарлах тухай" захирамжийн хэрэгжилтийг хангуулах, тус газрын орлогч дарга Х.Булгаагийн баталсан 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн "Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдийн техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих шалгалтын удирдамж" -ийн дагуу 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс техникийн хяналтын үзлэгийн төвийн оношлогч инженер нартай хамтран шугамын үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдийн</p>	

		уааны тортогжилтийн хэмжээ стандартын шаардлага хэрхэн хангагдаж буй эсэхэд хяналт шалгалт хийж ажилласан.	
30	30.1 Серверүүд, интернетийн болон дотоод сүлжээ, програм хангамжийн хэвийн ажиллагааг хангах, хөгжүүлэх, байгууллагад шаардлагатай програм хангамж, системүүдийг шинээр нэвтрүүлнэ.	<p>Нийслэлийн Мэдээллийн технологийн газар, хэрэглэгч нийслэлийн Тээврийн газар интернетийн үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдөр интернет нийлүүлэгч Комтел ххк, захиалагч байгуулж интернетийн хурдыг 7 (Мбит/сек) болгон нэмсэн.</p> <p>2018 оны 03 дугаар сарын 23–ны өдрийн 17 цаг 35 минутаас 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 цаг 00 минут хүртэл байгууллагын интернетийн урсгал тасарсантай холбогдуулан нийслэлийн Мэдээллийн технологийн газарт 03 дугаар сарын 30 өдөр шалтгаан тайлбарыг ирүүлэх, цаашид дахин тасрахгүй байх талаар анхаарч хамтран ажиллах тухай 3/393 тоот албан бичиг хүргүүлсэн.</p> <p>Байгууллагын I, III, XI давхруудын сүлжээний утаснуудыг цэгцлэх, шинээр татах, ашиглагдахгүй сүлжээний утаснуудыг хураах ажлыг гүйцэтгэхдээ 6 компьютерт шинээр сүлжээ татан, 3 сүлжээний төхөөрөмжийг ажиллагаанаас гаргасан. Мөн төв swich -ээс эхлэн сүлжээний утас бүрийг шалган хэрэглэгчийг тогтоон тухайн утсан дээр тэмдэглэгээ хийсэн. Байгууллагын дотоод сүлжээний зураглалын visio 2013 програм хангамжийг судлан XI давхар , I давхарын өрөөнүүдийн дотоод сүлжээний зураглалыг зурж, байгууллагын компьютер техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах, засвар үйлчилгээг хийх, шинэчлэн сайжруулах талаар удирдлагуудад танилцуулсан. Байгууллагын цагийн бүртгэлийн төхөөрөмж болох IFACE 302 төхөөрөмжөөс цагийн бүртгэлийн мэдээллийг татан боловсруулж тайлан мэдээ гаргах зорилгоор desktop програм хангамжийг хөгжүүлэн ашиглаж эхэлсэн.</p> <p>Нийслэлийн Мэдээллийн технологийн газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын компьютеруудыг нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулсан. Тус газарт 08 сарын 13-ны өдрийн 03/515 тоот албан бичгээр ирсэн загварын дагуу байгууллагын нийт компьютеруудын үзүүлэлтийн судалгааг гарган хүргүүлсэн. Үүний дагуу 45 компьютерыг нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбон, 13 компьютерын үзүүлэлт шаардлага хангаагүй тул холболт хийгээгүй болно.</p>	
31	31.1 Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын хэмжээнд дуудлагын нэг төвтэй болох дотуур холбооны системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	<p>Колл Про ХХК-ийн байгууллагын дотоод харилцаа холбооны системийг суурилуулж тус газрын хэмжээнд үйлчилгээг 02 дугаар сарын 14-ний өдрөөс ашиглалтанд оруулж, 323176, 326352 утасны дуудлагыг 70044040 утсанд хүлээн авч байна.</p> <p>Нийслэлийн тээврийн үйлчилгээний талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Колл Про ХХК-аас үйл ажиллагааны талаар мэдээлэл, танилцуулга хийсэн.</p> <p>Колл Про ХХК-ийн байгууллагын дотоод харилцаа холбооны системийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 20 аж ахуйн нэгж байгууллагуудад суурилуулж дууссан.</p> <p>Дотуур холбооны системийг цаг агаарын болон болзошгүй гамшигийн үеийн мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагуудад цаг алдалгүй хүргэх ажиллагаанд ашиглаж байна.</p>	
32	32.1 Өргөдөл гомдлын нийслэлийн	1. Иргэдийн санал гомдлыг 24 цагаар утсаар хүлээн авах ажлыг зохион байгуулсан.	

	<p>нэгдсэн программыг бүрэн нэвтрүүлж, нийслэлийн тээврийн үйлчилгээний талаар иргэд хэрэглэгчдээс гаргасан өргөдөл, гомдол, хариутай албан бичигт хууль эрх зүйн үндэслэлтэй хариуг хугацаанд нь өгч хэвшүүлэх. Иргэдээс он-лайн болон утсаар ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг агуулгаар нь ангилах, шийдвэрлэлтэнд хяналт тавих, дэлгэрэнгүй болон хандалтын тайланг гаргах, байгууллагын удирдлагуудыг шуурхай мэдээллээр хангаж ажиллана.</p>	<p>11 сарын байдлаар тухайлсан тээврийн хэрэгсэл болон жолоочтой холбоотой 3436, шугамын үйлчилгээтэй холбоотой санал 972 санал хүлээн авч ТТХэлтэс, ТХХэлтэс, ЗТҮХэлтэс, УБСК ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдэд шилжүүлж иргэдэд хариу мэдэгдсэн.</p> <p>Гомдлыг төрлөөр нь авч үзвэл: жолооч, шалгагчийн зан харьцаатай холбоотой-517, замын хөдөлгөөний аюулгүй байдал зөрчсөн-588, цагийн хуваарь баримтлаагүй-368, стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр үйлчилсэн-154, чиглэл зөрчсөн-19, автобусны зогсоол дээр зогсоогүй-567, үнэ тарифтай холбоотой-237, цэвэрлэгээ өнгө үзэмж-32, зогсоолын нэр зарлаагүй-2, үйлчилгээтэй холбоотой бусад гомдол-421, шугамын үйлчилгээтэй холбоотой-531.</p> <p>Гомдлын барагдуулалтыг үзвэл: Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн-989, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн-973, гомдол гаргагчийн буруу-293, байгууллага сахилгын арга хэмжээ авсан 565, холбогдох боломжгүй-59, гомдлын мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн-8, шугамын үйлчилгээтэй гомдлыг шалгаж, барагдуулсан -485, шийдвэрлээгүй-64.</p> <p>2. Өргөдөл гомдлын нийслэлийн нэгдсэн програмд 2018 оны 12 дугаар сарын 07-ны байдлаар байгууллагад нийт 666 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 649 өргөдөл, гомдлыг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн буюу дундажаар 97,5 хувийн биелэлттэй байна. Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлоос хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 7 өргөдөл, гомдол, шийдвэрлэх шатанд 10 өргөдөл, гомдол байна.</p> <p>Өргөдөл, гомдлын тайланг II, III улирлын байдлаар гарган 06 дугаар сарын 29-ны өдрийн 1/869, 10 дугаар сарын 05-ны өдрийн 1/1265 тоот албан бичгүүдээр НЗДТГ-ын НҮНТөвд хүргүүлсэн болно.</p>	
<p>33. Тус газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тухай нийслэлийн Удирдлагын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, ажлын тайланг эхний хагас жил, жилээр гарган нийслэлийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.</p>			
33	33.1 Ажлын төлөвлөгөө гаргана	Газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийсэн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/258 дугаар албан бичгээр НЗДТГ-н ХШҮХэлтэст хүргүүлсэн.	
34	33.2Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмжийг хэрэгжүүлэхээр нийт 14 ажил төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 99.3%-тай байна.	
	33.3 Ажлын тайланг хүргүүлнэ.	2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1/845, 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/1617 тоот албан бичгийг хавсралтын хамт НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн.	
<p style="text-align: center;">НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ОНОО</p>			

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Д/Д	Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)	Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ
<p>1. Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар “Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн ложистикийн төв” байгуулна./ 1.1.1.3.</p>			
1.1	<p>1.1.1 Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт ачаа тээврийн нэгдсэн ложистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулж, зүүн хэсгийн ложистикийн төв барих ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Уг ажлын хүрээнд дараах зохион байгуулалтын ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт ачаа тээврийн нэгдсэн ложистикийн төв байгуулах, ТЭЗҮ боловсруулахад хамтран ажиллах тухай саналыг НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэст 03 дугаар сарын 16-ны өдрийн 3/389 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. - Нийслэлийн зүүн хэсэгт нэгдсэн логистик төв барих 130 га газрыг 05 дугаар сарын 24-ний өдөр нийслэлийн мэргэжлийн байгууллагуудын хамт үзэж, танилцсан. - Нийслэлийн баруун хэсэгт нэгдсэн логистик төв барих 40 га газрыг шийдвэрлүүлэх, нийслэлийн газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөнд тусгах саналыг 05 дугаар сарын 29-ний өдрийн 2/697 дугаар албан бичгээр нийслэлийн Газрын албанд, газрын төлбөрийн асуудлыг шийдүүлэхээр Захирагчийн ажлын албанд 09 дүгээр сарын 06-ны өдрийн 1/1080 тоот албан бичиг хүргүүлсэн. - Логистик төв барих ажлыг удирдлагаар хангаж ажлын хэсэг байгуулан ажиллах шаардлагатай талаар 11 дүгээр сарын 23-ны өдрийн 4/1457 тоот албан бичгийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт тус тус хүргүүлсэн. <p>Орлогч П.Баярхүү эдгээр асуудлуудтай танилцаж, шийдвэрлэх зорилгоор ЗТХ-ийн орлогч сайд болон нийслэлийн холбогдох харьяа газруудын удирдлагуудтай уулзалт ярилцлага зохион байгуулж хамтран ажиллах талаар санал солилцож, чиглэл өгсөн.</p>	
	<p>1.1.1.2 Хотын баруун хэсгийн ачааны ложистикийн төвийг барих</p>	<p>“Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн ложистикийн төв” байгуулах ажлын хүрээнд баруун бүсийн ачааны ложистик төв байгуулах талаар</p>	

		<p>газрыг холбогдох байгууллагуудтай шийдвэрлүүлнэ.</p> <p>мэргэжлийн хамтран</p>	<p>хийсэн судалгааны дүн, танилцуулгыг ЗТХЯ болон НЗАА, НАЗХГ, НМХГ, ЗЦА, ЗХУТ-д 1-р сарын 15-ны өдрийн 4/78 тоот абан бичгээр хүргүүлсэний дагуу НЗАА-наас 2-р сарын 1-ний өдрийн 01/187, НМХГ 1-р сарын 22-ны өдрийн 02-03/332, ЗХУТ-өөс 1-р сарын 24-ний 03/118 тоот албан бичгээр тус тус дэмжиж ажиллах саналаа ирүүлсэн.</p> <p>1-р сарын 24, 2-р сарын 8, 26-ны өдрүүдэд ЗТХЯ-ны АТБХЗГ-ын дарга С.Батболд болон холбогдох ажилтнуудтай тус газрын орлогч дарга Г.Доржпаламаар ахлуулсан мэргэжилтнүүд "Номин холдинг" ХХК-ийн "Улаанбаатар импекс" агуулах худалдааны төвийн барилга, байгууламжийг түшиглэн ачаа тээврийн терминал байгуулах талаар санал солилцсон.</p> <p>3-р сарын 27-ны өдөр НЗД-ын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогчтой ЗТХЯ-ны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга н.Батболдтой уулзаж "Номин холдинг" ХХК-ийн "Улаанбаатар импекс" агуулах худалдааны төвийг баруун бүсийн ачаа тээврийн ложистик төв болгон зохион байгуулах, зүүн хэсгийн ачааны ложистик төвийг Амгалан орчимд байгуулах талаар саналаа танилцуулсан. 05 дугаар сард ЗТХЯ-ны сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нар Зам тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллах санамж бичгийг шинэчлэн баталсаны дагуу ЗТХЯ-тай санал солилцон хамтран ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ-ын эрх, үүрэг, хариуцлагыг "Олон улсын худалдаа, логистикийн төв" хаалттай хувьцаат компанид бүрэн шилжүүлсэн.</p> <p>Улаанбаатар хотын баруун бүсийн "Хангарди" олон улс, хот хоорондын автобус терминал, олон улсын худалдаа логистикийн төвийн барилгын шав тавих ёслол 10 дугаар сарын 11-ний өдөр болсон. Олон улсын худалдааны логистикийн төв нь нийт 24 автобусны гарцтай, 4200 ам метр талбай байхаар төлөвлөсөн байна.</p>	
<p>2. Эрх зүйн орчныг шинээр бүрдүүлнэ. Хотын дэд бүтцийг хөгжүүлэх эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлнэ./ 2.1.2</p>				
2.1	2.1.1 Хотын дэд бүтцийн норм, нормативын баримт бичгийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв	2.1.1.1 Нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийн орон тоог батлагдсан бүтцийн хүрээнд шийдвэрлэнэ.	Сүлжээ төлөвлөлтийн албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэх саналыг гаргаж, Зорчигч тээврийн сүлжээ төлөвлөлтийн мэргэжилтэн, Судалгаа, шинжилгээний мэргэжилтэн 2 ажлын байрыг нэгтгэн "Нийтийн тээврийн судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн" болгон өөрчилж 3 албан хаагч шинээр нэмэх, ажлын ачааллыг харгалзан график төлөвлөлтийн мэргэжилтэний орон тоог нэгээр нэмж нийслэлийн тээврийн салбарын мэдээллийн урсгалыг орчин үеийн арга технологи, програм хангамж	

	байгууллагад саналаа хүргүүлнэ.		ашиглан судалж, шинжилж, дүгнэлт санал боловсруулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж байхаар тусгав. 04 дүгээр сарын 19-ний өдрийн НИТХ-д дээрх бүтцийн талаарх саналаа танилцуулсан.	
		2.1.1.2 Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийн шаардлагатай норм нормативыг шинэчлэх ажилд санал тусгуулж ажиллана.	“Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам”-ын төсөлд хариу хүргүүлэх тухай албан бичигт хэлтсийн дарга нараас санал авч, 2/65 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Төслийн ажлын явцаас хамааран тухайн жилд хийгдээгүй. Тус газрын зүгээс шалтгаалсан зүйл байхгүй.	
3. Эрх зүйн орчныг шинээр бүрдүүлнэ. Хотын дэд бүтцийг хөгжүүлэх эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлнэ./ 2.1.2				
		2.1.1.3 Автотээврийн стандартчиллын техникийн хорооны стандартчиллын ажлын төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан стандартуудыг шинэчлэхэд санал боловсруулан хүргүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	ЗТХЯ-ны стандарт хариуцсан мэргэжилтэнтэй уулзаж MNS 5012:2011 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага стандартыг шинэчлэхэд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 20 аж ахуйн нэгж байгууллагуудаас санал авч нэгтгэж өгсөн. Үүнд: 1. Үйлдвэрлэгч орны ашиглалтын жил 2. Хөдөлгүүрийн судалгаа 3. Дахин ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн насжилтын хугацаа зэрэг болно. Автотээврийн стандартчиллын техникийн хороодын 2018-2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөөний төсөлд санал нэгтгэн 2/13 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Автотээврийн стандартчиллын техникийн хороо 2018-2019 оны хийгдэх ажлын хүрээнд аж ахуйн, нэгж байгууллагуудаас "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2011 стандартад ирүүлсэн саналыг авч нэгтгэн, шинэчлэн найруулан, тус газрын холбогдох хэлтэс, удирдлагуудаас санал авч байна.	
4. Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох судалгаа явуулах. / 2.5.1				
3.1	3.1.1 Хөшигийн хөндийн нисэх буудлыг нийтийн тээврийн үйлчилгээтэй холбох ажлын хүрээнд холбогдох судалгаа хийн дүгнэлт гарган, төлөвлөлтийн санал	3.1.1.1 Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран Улаанбаатар хот доторх аялах чиглэлийн маршрутыг төлөвлөнө.	ЗТХЯ-ны сайдын зөвлөлийн 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орохтой холбогдуулж нийтийн тээвэр болон бусад тээврийн үйлчилгээний зохион байгуулалтын талаар хэлэлцэж "НЗДТГ, НТЭГ хамтран зохион байгуулах нь зүйтэй" гэсэн шийдвэр гаргасан. ЗТХЯ-ны сайдаас НЗД-д 01 дүгээр сарын 23-ны өдөр “Нисэх онгоцны шинэ буудлаас Улаанбаатар хотын хооронд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулахаас гадна олон улсын жишгээр нисэх төв буудалд автотээврийн нэг цэгийн үйлчилгээ, иргэдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн бусад шинэлэг үйлчилгээг зөвлөмжийн дагуу зохион байгуулахаар холбогдох арга хэмжээ авч ажиллах” талаар 01/345 дугаар	

	<p>боловсруулж танилцуулна.</p>		<p>албан бичиг ирүүлсэн. ИНЕГ-ын даргын 2018 оны А/43 дугаар тушаалаар Улаанбаатар хотын олон улсын нисэх буудлын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, нүүлгэн шилжүүлэх ажлын хэсэг болон дэд бүтэц, шатахуун, хангамж, нийтийн тээврийн үйлчилгээ хариуцсан ажлын хэсгийг байгуулсан ба бүрэлдэхүүнд тус газрын мэргэжилтэн оролцон ажиллаж байна. ЗТХЯ-аас 03 дугаар сарын 16-ны өдөр 07/1139, ИНЕГ-аас 03 дугаар сарын 15-ны өдөр 17/804 дугаар албан бичгээр ажлын хэсэгт орох албан тушаалтны нэр ирүүлж хамтарсан ажлын хэсгийг 03 дугаар сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаалаар байгуулсан. ИНЕГ-ын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн тодорхой ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт нийслэлээс 52 км-ийн зайд ОУ-ын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтанд орж байгаатай холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхээр холбогдох судалгааг хийсэн. Хөшигийн хөндийн буудалд дотоодын ба гадаадын авиа компаниуд олон улсын болон орон нутгийн нислэг үйлдэх ба нисэх онгоцны буудлаар сард дунджаар 800-1000 орчим нислэгээр 151000 зорчигч үйлчлүүлэх урьдчилсан төлөвлөгөөтэй байгаа талаар гарсан судалгааны дүнд үндэслэн "Шинэ нисэх-Драмын театр" чиглэлийн төлөвлөлтийг боловсруулж 60 минутын интервалтай 45 хүний суудалтай жуулчны автобусаар үйлчилгээ үзүүлэх боломжтой талаар төлөвлөлтийн санал боловсруулсан. НЗД-ын 2015 оны А469 дүгээр захирамжийн хүрээнд Аялал, жуулчлалын автобусны үйлчилгээний шаардлагатай чиглэлүүдийн маршрут төлөвлөх зорилгоор шаардагдах судалгаа, жуулчдын хамгийн их эрэлттэй цэгүүдийг тодорхойлж холбогдох хэмжилт тооцооллыг хийж байна. Олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтанд орж байгаатай холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхээр холбогдох судалгааг хийсэн. Дээрх судалгааны дүнд нийтийн тээврийн үйлчилгээг 3 чиглэлд хүргэхээр төлөвлөсний дагуу төлөвлөлтийг 3 хувилбарт саналаар боловсруулж 08 дугаар сарын 16-ны өдөр Зам тээврийн хөгжлийн яамны холбогдох албан тушаалтнуудад, 09 дүгээр сарын 06-ны өдөр Засаг даргын орлогч П.Баярхүүд, 10 дугаар сарын 04-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг чиглэл авсан.</p>	
--	---------------------------------	--	--	--

5. Нийтийн тээврийн үр өгөөжийг дээшлүүлэх мастер төлөвлөгөө шинээр боловсруулна. /2.5.13/

4.1	4.1.1	Нийтийн	4.1.1.1 Нийтийн тээврийг хөгжүүлэх	Нийтийн тээврийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулахад
-----	-------	---------	------------------------------------	---

	тээврийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө шинээр боловсруулж батлуулна.	мастер төлөвлөгөө шинээр боловсруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг зээл тусламжийн хүрээнд шийдвэрлүүлж, судалгаа боловсруулалтын ажлыг хийнэ	шаардагдах хөрөнгө энэ онд шийдвэрлэгдээгүй бөгөөд 2019 оны төсвийн төсөлд тусгуулахаар санал өгсөн. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого” батлагдсан. Үүнтэй уялдуулан газрын даргын 12 дугаар сарын 03-ны өдрийн А/88 дугаар тушаалаар “Нийтийн тээврийн салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр шинээр байгуулах тухай” ажлын хэсэг байгуулагдан 2019 оны 01 дүгээр сарын 25-ны дотор дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж танилцуулахаар болсон.	
6. Автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ. 2.5.15 /ЗГҮАХ-ийн 2.2.24 дэх заалт/				
5.1	5.1.1 Тусгай замын автобус /BRT/-ны шугамын ажлын зураг төслийг боловсруулна.	5.1.1.1 Нийслэлийн нийтийн тээвэрт тусгай замын автобус /BRT/ -ны төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж, тусгай замын автобусны төслийн 1-р үе шатыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана.	Тусгай замын автобус (ТЗА)-ны сүлжээний гурван коридорын нарийвчилсан зураг төсөл боловсруулах, 1 коридорын барилгын ажлын хяналт гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ болон Ухаалаг тээврийн системийн /УТС/ зөвлөх үйлчилгээг тус тусад нь зарлахаар төслийн удирдлагын газрын авлага /ТУГА/, худалдан авах ажиллагааны /ХАА/ төлөвлөгөө, төслийн удирдах хорооны 2017 оны тогтоолд тусгагдсан. ТЗА-ны сүлжээний гурван коридорын нарийвчилсан зураг төсөл боловсруулах, 1 коридорын барилгын ажлын хяналт гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг 2017 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалт үргэлжилсээр 2018 оны 8 дугаар сард гэрээний хэлэлцээр амжилтгүй болж дахин зарлахаар шийдвэрлэсэн. Төслийн Техникийн ажлын хорооны 2018 оны 08 сарын 28-ны өдрийн хурлаар эхний шатанд хэрэгжих босоо коридор буюу Нисэхээс Долоон буудал чиглэлд хэрэгжүүлэх саналыг дэмжиж ТЗА-ыг Энхтайваны гүүрийг ашиглаж хийх бөгөөд тус гүүрийн зүүн талын нүхэн гарцны нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, баруун талд шинээр нүхэн гарц хийх чиглэлүүд өгсөн. Уг үүрэг даалгаврын дагуу төслийн явцыг эрчимжүүлэх 2019 онд барилгын ажлыг хэсэгчлэн эхлүүлэх үүднээс “коридор 1”-ийг дотор нь 1А, 1Б хэсэгт хувааж “1А” хэсгийг 1А-1, 1А-2, 1А-3 дэд хэсгүүдэд хуваасан. “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Төслийн Удирдах Хорооны бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/844 тоот захирамжаар шинэчлэн баталсан.	

			<p>ТУХ-ны ээлжит хурал 2018 оны 11 сарын 2-6-ны өдрүүдэд хуралдаж Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Төсөл 1-ийн “Төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”, “Тусгай замын автобусны сүлжээний чиглэл, коридоруудын хэрэгжүүлэх дараалал”, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц зохион байгуулалтыг баталсан.</p> <p>Төслийн удирдах хорооны уг хурлын шийдвэрийн дагуу төсөл хэрэгжүүлэх үе шатыг нарийвчилж улмаар 1А коридорыг буюу Яармагаас Сүхбаатарын талбай хүртэлх коридорын бүтээн байгуулалтын ажлыг 3 багц болгож хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энхтайваны гүүрээр ТЗА-ыг явуулж улмаар одоо байгаа ачааллыг өнгөрүүлэх шинэ гарцыг тус гүүрийн баруун талаар төлөвлөсөн. Урьдчилсан төлөвлөлтийг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн тээврийн инженер, авто зам, хийцийн инженерүүд хамтран Нарын зам болон Төмөр зам доогуур нийтдээ 130 км нүхэн гарцтай, үндсэн замыг эсрэг хөдөлгөөнтэй, чиглэл бүрдээ тус бүр 2 эгнээтэй, Дунд гол дээгүүр хоёр талд нь гэрлэн дохиотой уулзвар шинээр бий болох /ойрхон/ тул зүүн баруун эргэлтүүдийг тооцож 6 эгнээтэй байдлаар төлөвлөсөн. Шинэ гарцын төлөвлөлтийг нийслэлийн Газрын алба, нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, нийслэлийн Авто замын газар, Улаанбаатар Төмөр зам болон бусад бүх шугам сүлжээний байгууллагууд руу 11 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд албан тоотоор хүргүүлж саналыг авч авч байна.</p> <p>Хэрэгжүүлэх дараалал Авто зам, гудамж, талбайн нэршил Авто замын урт, /км/ Төслийн удирдах хорооны 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар шинэчлэн баталсан.</p> <p>ТЗА-ны дэд бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах ажлын даалгаврыг УТС-ийн зураг төслийг боловсруулах ажлын даалгавартай нэгтгэн ажлын даалгаврын цар хүрээнд өөрчлөлт орж дахин боловсруулж байна. Төслийн төлөвлөгөө, тайлан, биелэлтийг сар, улирал бүр нэгтгэн авч, мэдэлэл солилцон ажиллаж байна.</p>	
7. Нийтийн тээврийн санхүүгийн бие даасан байдлыг хангах менежмент хэрэгжүүлнэ./ 2.5.16				
6.1	6.1.1 Нийтийн тээврийн аж ахуйн нэгжтэй урт хугацааны тогтвортой гэрээг байгуулж, бие	6.1.1.1 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй урт хугацааны тогтвортой гэрээ байгуулна.	Их болон дунд багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх тогтвортой гэрээний төслийг боловсруулж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулсан. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж “Нийтийн тээврийн үйлчилгээний санхүүжилтийн гэрээ”-ний төслийг хэлэлцэж холбогдох	

<p>даасан санхүүгийн чадавхыг нэмэгдүүлнэ.</p>		<p>санал авахаар танилцуулсан ба уг гэрээний төсөлд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Хууль эрх зүйн хэлтсээс холбогдох саналыг авч тусган 04 дүгээр сарын 12-ны өдөр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай Санхүүжилтийн гэрээ байгуулсан.</p> <p>Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх урт хугацааны гэрээний төслийг боловсруулан 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 1/1057 тоот албан бичгээр шинэчилсэн гэрээний төсөлд санал авахаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 19 аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан сонсох ажиллагааг 08 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>Гэрээний төслийг эцэслэн боловсруулж дахин санал авахаар 19 аж ахуйн нэгж байгууллагуудад 10 дугаар сарын 19-ний өдрийн 1/1316 тоот албан бичгээр хүргүүлэн, саналыг бичгээр авч, Захиргааны зөвлөлийн 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралд танилцуулсан.</p>	
	<p>6.1.1.2 Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдэд эдийн засгийн тооцоо судалгааг хийж алдагдал ихтэй чиглэлүүдэд цаашид авч хэрэгжүүлэх төслийн санал боловсруулан шийдвэрлүүлнэ.</p>	<p>Аж ахуйн нэгж, байгууллагуудын үйлчилж буй чиглэлүүд хооронд зохицуулалт хийх боломжийг судалж, "Сутайн Буянт" ХХК болон "Эрдэм Транс" ХХК-ийн үйлчилгээ үзүүлдэг чиглэлүүдийн тээврийн хэрэгслийн тоо, ажлын гүйцэтгэл, зорчигч урсгал, орлого төвлөрүүлэлт болон гарсан зардал, 1 цагт ноогдох 1 тээврийн хэрэгслийн орлого, 1 тээврийн хэрэгслийн тээсэн зорчигчийн тоо, эргэлтийн урт, эргэлтийн хугацаа, гүйцэтгэх рейсийн тоо зэргийг харгалзан үзэж "Сутайн Буянт" ХХК-ийн Ч:49 чиглэлээс 1 гаралтыг хасч Ч:18А чиглэлд 2 гаралтыг нэмэгдүүлэх, "Эрдэм Транс" ХХК-ийн Ч:6 чиглэлээс 1 гаралтыг хасч Ч:20Б чиглэлд 2 гаралт нэмэгдүүлэх саналыг тус тус гарган графикийг хийлгэж, тухайн 2 аж ахуйн нэгжтэй уулзан холбогдох саналыг аваад байна.</p>	
	<p>6.1.1.3 Нийслэлийн тээврийн үйлчилгээний үнэ тарифын бодит тооцоо, судалгааг гарган танилцуулж цаашид авч хэрэгжүүлэх ажлын саналын төсөл боловсруулна.</p>	<p>1. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн тайлан мэдээ, тээвэрлэлтийн мэдээ тайлан, санхүү эдийн засгийн үзүүлэлтийн дүн мэдээнд үндэслэн салбарын хэмжээнд зардлыг авч үзэн үндсэн чиглэлийн бодит тарифын тооцоо, судалгааг хийв. Салбарын хэмжээнд гарсан зардлыг зорчигч урсгалд харьцуулан үзэхэд нэг зорчигчийн хөлс төлөлтийн дундаж хэмжээ 800 төгрөг байхаар байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар мэдээ, тайлан ирүүлсэн аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд авч үзэхэд нэг зорчигчийг тээвэрлэх зардал 630 төгрөг байна.</p> <p>2. Нэг тээврийн хэрэгслийн нэг зорчигч тээвэрлэхэд гарсан зардал, олсон орлого, 1 километрт нэг зорчигч тээвэрлэх зардлыг тооцоолон зайнаас хамаарсан үнийг тооцоолсон. Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нь тухайн чиглэлд ялгаатай тариф мөрдөх</p>	

			<p>боломжгүйгээс чиглэл бүрийн орлого, зардал, зорчигч урсгал, эргэлтийн урт, өмнө мөрдөгдөж буй үнэ тариф, давхцаж буй чиглэлүүдийн үнэ тарифыг харгалзан үзэж тухайн чиглэл бүрээр мөрдөх нэг үнэ тарифыг тооцож, санал дүгнэлтийг гарган ажлын хэсэгт танилцуулсан. Судалгаа тооцооллыг дэлгэрүүлэн гэрээний мэргэжилтэнд өгсөн ба ажлын хэсгийн санал дүгнэлтийг гаргаж Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэж байна.</p>	
<p>8. 2.5.17. Нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийж, иргэдийн эрэлтэд нийцсэн шинэ чиглэл бий болгоно./ 2.5.17 /ЗГҮАХ-ийн 2.222 дэх заалт/</p>				
	<p>8.1.1 Нийтийн зорчигч тээвэрт парк шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>8.1.1.1 Нийтийн тээврийн дотоодын болон гадаадын байгальд ээлтэй тээврийн хэрэгслийн харьцуулсан судалгааг гаргаж, парк шинэчлэл хийхэд шаардлагатай мэдээллээр удирдлагуудыг хангаж ажиллана.</p>	<p>1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “Эрдэм транс” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн автобус болон БНСУ-д үйлдвэрлэгдсэн Hyundai Universe маркийн автобусны техникийн үзүүлэлтийн харьцуулсан судалгааг хийж НЗД-ын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү болон “Эрдэм транс” ХХКомпанид 02 дугаар сарын 13-ны өдрийн 2/233 тоот албан бичгээр хүргүүлэв.</p> <p>2.Тус газрын бүртгэлийн санд бүртгэлтэй автобус, троллейбусны техникийн үзүүлэлтийн судалгааг гарган нэгтгэсэн.</p> <p>3. БНСУ-ын Засгийн газраас авах 500 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийг танилцуулах асуудлаар БНСУ-ын Экспорт-Импорт банкны ажлын хэсгийн төлөөлөгчдөд "Улаанбаатар хотын нийтийн тээврийн паркийг байгалийн шахсан хийн хэрэглээ бүхий автобусаар шинэчлэх төсөл"-ийг дахин шинэчлэн танилцуулсан. Уулзалтын хүрээнд шаардлагатай нэмэлт тодруулга мэдээллийг гаргаж Холбогдох газарт хүргүүлсэн.</p> <p>4. 03 дугаар сарын 16-ны өдрийн 3/349 тоот албан бичгээр парк шинэчлэл хийх саналыг НЗД-ын орлогч П.Баярхүүд хүргүүлсэн.</p> <p>2018 оны эхний 11 сарын байдлаар үндсэн чиглэлийн 16 аж ахуйн нэгж байгууллага 145 их багтаамжийн автобусаар парк шинэчлэлтийн хүрээнд нөхөн хангалт хийсэн. Үүнд байгалийн шатдаг хийгээр ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоноглолтой 5 автобус оруулж ирсэн.</p>	
		<p>7.1.1.2 Нийтийн тээврийн хэрэгслийг байгальд ээлтэй технологид шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, байгалийн шатдаг хийгээр (CNG) ажилладаг тэжээлийн системтэй автобусаар парк шинэчлэлт хийнэ.</p>	<p>1. “Автотээврийн тухай” хууль, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2011, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 улсын стандартуудын шаардлагыг хангаж, техникийн хяналтын үзлэгт хамрагдаж тэнцсэн тул Авто тээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан.</p> <p>2. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 7 аж ахуйн нэгж байгууллага</p>	

			байгалийн шахсан хий (CNG)-ээр ажилладаг 68 автобусыг парк шинэчлэлтийн хүрээнд оруулж ирсэн.	
9. 2.5.17. Нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийж, иргэдийн эрэлтэд нийцсэн шинэ чиглэл бий болгоно./ 2.5.17 /ЗГҮАХ-ийн 2.222 дэх заалт/				
7.2	7.2.1 Нийтийн тээврийн эцсийн зогсоолд зорчигч, тээвэрчдэд зориулсан үйлчилгээний цогцолборыг барина.	7.2.1.1 Нийтийн тээврийн эцсийн зогсоолын зорчигч, тээвэрчдэд зориулсан үйлчилгээний цогцолборуудад засвар хийнэ.	<p>Нийслэлийн Тээврийн газар, Өмчийн харилцааны газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/72, А/425 дугаар хамтарсан тушаалаар автобусны эцсийн зогсоолын барилга байгууламжуудын ашиглалтын талаар дүгнэлт гаргах, ашиглалтын гэрээний төслийг боловсруулах, гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Ажлын хэсэг нь 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж, урьдчилсан байдлаар 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдөр нийслэлийн Өмчийн харилцааны газар “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын төлөөлөл дахин газар дээр нь танилцсан.</p> <p>Нийслэлийн Тээврийн газар, нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран 2018 оны 06 дугаар сард “Улиастай, Шархад, Дэнжийн 1000, Нисэх, Баянхошуу” гэсэн автобусны эцсийн 5 зогсоолын барилга байгууламжийг ашиглуулах гэрээ байгуулан “Зорчигч Тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн болно. Дээрх ашиглагч байгууллагаас нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолуудын барилга байгууламжийн засварын ажлын төсвийн төслийг “Барилгын хөгжлийн төв”-өөр хянуулж, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулан тус газарт ирүүлсэн. 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 2/1111 тоот албан бичиг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. 09 дүгээр сарын 10-ны өдөр нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендерийн ажлыг зарлаж, 10 дугаар сарын 10-ны өдөр нээлтээ хийсэн. Уг тендерт "Босго толгой" /Баянхошуу, Дэнжийн 1000/, "Юу Зэт Эрдэнэ" /Шархад/, "Роял алтай констракшин" /Улиастай/, "Эрхэс напелл ХХК" / Нисэх/ компаниуд сонгон шалгаран 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Засаг даргын тамгын газрын холбогдох хүмүүс уг компаниудтай гурвалсан гэрээ хийсний дагуу 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн засварын ажлыг хийж гүйцэтгэж байна. Нийтийн тээврийн эцсийн зогсоолын зорчигч, тээвэрчдэд зориулсан үйлчилгээний цогцолборуудын засварын ажилд хяналт тавих 4 инженер томилогдон хяналт тавин ажиллаж байна.</p>	

	<p>7.2.2 Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд судалгаа хийх, хөдөлгөөний нягтралыг бууруулах, тээврийн төлөвлөлтийг боловсронгуй болгох</p>	<p>7.2.1.2 Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхардлыг бууруулах зорилгоор иргэдийн санал хүсэлтийн дагуу чиглэлүүдийг богиносгох судалгаа хийж сүлжээ төлөвлөлтийг боловсронгуй болгоно.</p>	<p>2018 онд иргэдийн санал хүсэлт, зорчих эрэлтийн дагуу нийт 2 чиглэл шинээр нээж, 12 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан байна. Үүнээс чиглэлийн замналыг богиносгож, давхцал бууруулсан ажлыг дурдвал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлд хийгдэж буй бүтээн байгуулалтын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн байдлыг хангахын тулд гаралт нэмэгдүүлэх, чиглэл өөрчлөх, шинээр нээх чиглэлүүдийн төлөвлөлтийг боловсруулан эдийн засгийн тооцооллыг хийж 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Дээрх төлөвлөлтөд нийтийн тээврийн чиглэлийн давхардлыг бууруулах саналууд тусгагдсан. 2. Ч:36 “Гачуурт-Офицеруудын ордон-Зайсан” чиглэлийн зорчигч урсгалын судалгаа болон бусад холбогдох судалгааг хийж чиглэлийн замналыг богиносгож 2 чиглэл болгон хуваах төлөвлөлтийн санал боловсруулан Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулсан. Тус газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/51 дугаар тушаалаар баталгаажуулсан. 3. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхардлыг бууруулах зорилгоор иргэдийн санал хүсэлтийн дагуу чиглэлүүдийг богиносгох судалгаа хийгдсэний дагуу нийтийн тээврийн үйлчилгээний Ч:8 чиглэлийг богиносгох төлөвлөлтийн саналыг боловсруулан Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулан тус газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/47 дугаар тушаалаар баталгаажуулсан. 4. Нарны зам дагуу Хермэс худалдааны төв зогсоол шинээр гаргуулан Энхтайваны өргөн чөлөөний давхацлыг бууруулах зорилгоор Ч:46 “Улаан чулуут-Их наран-Вокзал” чиглэлийн замналд өөрчлөлт оруулан 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/49 тушаалаар баталгаажуулсан. 	
	<p>7.2.3 Хотын захын суурьшлын бүсүүдэд нийтийн тээврийн үйлчилгээний дундын зогсоолуудыг стандартын дагуу тохижуулна.</p>	<p>7.2.3.1 Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хийгдэх дундын зогсоолуудын саналыг гарган НАЗХГ-т танилцуулан шийдвэрлүүлж, ажлын зураг төсөлд санал тусгуулан, дундын зогсоолуудыг стандартын дагуу гүйцэтгэлийн ажилд хяналт тавин хүлээн авч ажиллана.</p>	<p>2018 онд нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хийгдэх дундын зогсоолуудын саналыг Нийслэлийн дүүргүүд болон Иргэдийн хурлын төлөөлөгчдөөс санал авч эрэмбэлэн нэгтгэж НАЗХГ, ЗЦА, НГА-тай хамтран газар дээр нь ажиллаж 14 зогсоол шинээр байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнд: 15-н зогсоол (Гачууртын автозамын урд, хойд), Оргил худалдааны төв (Товчооны зам урд, хойд), 6 буудал Оргил (урд, хойд), Говь-2 (Эрчим хүчний гудамж урд, хойд), Хаан банкны буудал (Дамбадаржаа урд, хойд), 626-р худаг, Шинэ зогсоол (Дэнжийн мянган гудамж урд, хойд), Дэлгэр хотхон (Үйлдвэрийн гудамж хойд) 05 дугаар сарын 24-ний өдөр НАЗХГ-ын холбогдох хүмүүстэй хамтарч батлагдсан жагсаалтын дагуу хийгдэж байгаа 14 зогсоолтой газар дээр нь очиж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажлын хэсэг</p>	

			байгуулагдсан. 2018 онд хийгдсэн зогсоолууд нь 3 үндсэн багцад хуваагдсан. 07 дугаар сарын 05, 08 дугаар сарын 16-ны өдөр "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт"-аар зогсоолуудыг тус тус хүлээн авсан. 09 дүгээр сарын 10-ны өдөр дээрх зогсоолуудын координатыг тогтоон, тус газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталсан 59/2018, 45/2018, 46/2018 дугаартай комиссын актаар тус тус баталгаажсан.	
		7.2.3.2 Жэй Си Деко Монголиа ХХК-тай хамтарч ажиллах гэрээний дагуу нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолуудыг стандартын дагуу тохижуулна.	2018 онд Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийтийн тээврийн хэрэгслийн зориулалтын 14 зогсоол гаргах ажилд нийслэлийн Автозамын хөгжлийн газар, Замын цагдаагийн алба, нийслэлийн Газрын албатай хамтран газар дээр нь ажилласан ба ажлын гүйцэтгэл бүрэн дуусч 2018 оны 08 дугаар сарын 16-ны өдөр нийслэлийн Авто замын хөгжлийн газар, тус газраас Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс байгуулагдаж 14 зогсоолыг хүлээн авсан. Жэй Си Деко Монголиа ХХК-нд аудитын шалгалт хийгдэж тохижилт хийгдсэн 139 зогсоол, 150 мэдээллийн самбарыг газар дээр нь очиж шалгаж тоо, хэмжээ гаргасан. Аудитын эцсийн дүгнэлт гарсанаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай дахин уулзалт төлөвлөсөн. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, тус газар нь Жэй Си Деко Монголиа компанитай байгуулсан гэрээ түүний өөрчлөлт, санамж бичгийн хүрээнд 2018 онд 50 автобусны буудлыг олон улсын жишигт нийцүүлэн тохижуулахаар болсон. 2018 оны 09 дүгээр сарын 31-ний өдөр 50 байршилд дэлхий стандартад нийцсэн автобусны зогсоолын байгууламжийг угсарч дууссан. 10 дугаар сарын 01-ний өдөр Жэй Си Деко Монголиа ХХК-ийн техникийн ахлах ажилтантай хамтран 50 зогсоолыг шалгасан. Барилга байгууламжийг хүлээж авахаар бэлтгэл ажил хангагдаад байна. Мөн Нийслэлийн 2019 оны хөрөнгө оруулалтын төсөвт "Хотын захын суурьшлын бүсүүдэд нийтийн тээврийн үйлчилгээний дундын зогсоолуудыг стандартын дагуу тохижуулах" саналыг тусган ажилласан.	
10. Нийтийн тээврийн хэрэгслийг байгальд ээлтэй технологид шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, эко автобус, троллейбусны хэрэглээг нэмэгдүүлнэ. /2.5.18 /ЗГҮАХ-ийн 2.222 дэх заалт/				
8.1	8.1.1 Нийтийн тээврийн дизель автобусанд	8.1.1.1 Нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээний авто тээврийн хэрэгсэлд байгалийн	"Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа том оврын автобусанд байгалийн хийн түлш ашиглах төсөл"-ийн хүрээнд Юу Би Метан ХХК болон Улаанбаатар байгалийн хий ХХК нь нийтийн	

	<p>угааны тортог шүүгч DPF, түүнийг цэвэрлэх тоног, төхөөрөмжийг суурилуулан байнгын үйлчилгээ хийнэ.</p>	<p>шатдаг хий нэвтрүүлэх төслийг холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.</p>	<p>тээврийн автобусыг байгалийн шахсан хийгээр цэнэглэх үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>1. "Юу би Метан" ХХК нь Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан 60 м²х3 ширхэг хүчин чадал бүхий нийтийн тээврийн автобусыг байгалийн шахсан хийгээр цэнэглэх станцын зориулалттай барилга, байгууламжийг ашиглалтад оруулах талаар 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 2018/146 дугаар дүгнэлт гарсан. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч Эрдэм транс ХХК нь байгалийн шахсан хий (CNG)-гээр ажилладаг тэжээлийн системтэй 6 автобусаар 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 03 дугаар сар хүртэл хугацаанд туршилтын журмаар ажилласан ба нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 7 аж ахуйн нэгж байгууллага байгалийн шахсан хийгээр ажилладаг 68 (CNG) автобусаар парк шинэчлэлт хийж үүний 60 автобус шугамын үйлчилгээнд явж "Юу би Метан ХХК-ийн байгалийн шахсан хий цэнэглэх станцаас түлшээ авч байна.</p> <p>2. "Улаанбаатар байгалийн хий" ХХК нь 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/73 дугаар албан бичгээр автомашин хийгээр цэнэглэх станцыг Улаанбаатар хотын 5 бүс хэсэгт байгуулахаар төлөвлөж байгаа ба "Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа том оврын автобусанд байгалийн хийн түлш ашиглах төсөл"-ийн хүрээнд байгалийн хий хадгалах агуулах болон авто тээврийн хэрэгсэл хийгээр цэнэглэх станцыг 2019 оны 2 дугаар улиралд багтаан үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Одоогийн байдлаар агуулах, түгээх станцуудын сав болон бусад тоног төхөөрөмж захиалагдан Улаанбаатар хотод орж ирсэн, байгалийн хий хадгалах агуулахын суурийн болон шингэрүүлсэн байгалийн хийн түлш хадгалах сав суурилагдсан. 2019 оны 3 дугаар сараас эхлэн түгээх станцуудын угсралтын ажил эхлэх бөгөөд үүнээс өмнө байгалийн шингэрүүлсэн хийн стандарт, норм дүрэм батлуулах шаардлагатай байгаа тухай мэдээллийг ирүүлсэн.</p> <p>3. 2018 оны 10 дугаар сарын 25, 11 дүгээр сарын 13-ны өдрүүдэд Улаанбаатар байгалийн хий ХХК болон Юу Би Метан ХХК тай ажлын явц, цаашид хийгдэхээр төлөвлөж буй ажлуудын талаар уулзалт зохион байгуулж ажилласан.</p> <p>4. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газар, нийслэлийн Мэргэжлийн</p>	
--	---	--	--	--

			<p>хяналтын газар, Хий хангамжийн инженерийн нийгэмлэгийн хамтарсан даралтат сав, шугам хоолой, хийн тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах эрх олгох сургалтад нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 6 аж ахуйн нэгжийн 56 жолооч хамрагдаж хийн хөдөлгүүртэй автобус жолоодох эрхтэй болсон.</p>	
		<p>8.1.1.2 Нийтийн тээврийн дизель автобусанд 24 ширхэг утааны тортог шүүгч DPF, түүнийг цэвэрлэх тоног, төхөөрөмжийг суурилуулна.</p>	<p>1.Тус газар Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны "ЖАЙКА" байгууллагын төлөөлөгчид, төслийг хэрэгжүүлэгч нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 2 байгууллагатай хамтарсан уулзалтыг эхний хагас жилийн байдлаар 9 удаа зохион байгуулсан.</p> <p>2.Сутайн буянт ХХК нь тортогжилт шүүгч DPF төхөөрөмжийг их багтаамжийн автобусанд суурилуулах төсөлд хамтарч ажиллах саналаа 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/077 тоот, Зорчигч Тээврийн Нэгтгэл ОНӨААТҮГ-аас 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1/1313 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн.</p> <p>3. Дээрх байгууллагуудад төслийн хэрэгжилтийн явцад ашиглах шатаах зуух байрлуулах байрны асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>4. “Ногоон технологи, эрчим хүчний хэмнэлт-2018” үзэсгэлэнд /DPF/ утааны тортог шүүгч төхөөрөмжийг суурилуулж туршсан 1-144 гарааш дугаартай автобусыг иргэд, олон нийтэд сурталчилсан.</p> <p>5. Японы олон улсын хамтын ажиллагааны JICA байгууллагын буцалтгүй тусламжаар дизель хөдөлгүүрээс ялгарах хөө тортогжилтын ялгарлыг бууруулах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээний "Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазын 8 автобус, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 3 дугаар баазын 8 автобус, Сутайн буянтХХК-ийн 8 автобус нийт 24 автобусанд DPF шүүлтүүрийг суурилуулах ажил бүрэн хийгдэж дууссан.</p> <p>Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ийн төслийн удирдагч Комори Масанори, Ватанабэ Хисаяа, Сато Ацүши, Б. Батсүх нартай шүүлтүүр суурилуулснаас хойшхи үр дүн, хэрэгжилтийн явцын талаар 2018 оны 10 дугаар сарын 09, 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд тус тус хуралдсан. Шүүлтүүр суурилуулсан 3 аж ахуйн нэгж байгууллагаас тогтмол хөө тортог шүүсэн хэмжилт болон бусад хэмжилтүүдийг нэгтгэж, тайлагнаж байна.</p> <p>DPF шүүлтүүр суурилуулснаас хойш 24 автобусанд суурилуулсан утааны тортог шүүгч DPF, түүнийг цэвэрлэх тоног, төхөөрөмжүүд нь хэвийн ажиллаж байгаа бөгөөд судалгааны дүнгээр автобуснаас ялгарах хөө тортогжилт (PM)-ийг 98% хүртэл бууруулж байгаа ба нийт 259.483 кг хөө</p>	

			тортогжилт шүүсэн байна.	
11. Эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн ухаалаг системийг боловсронгуй болгоно./2.5.19/				
9.1	9.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд динамик цагийн хуваарийг ашиглаж эхэлнэ..	9.1.1.1 Динамик графикийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана.	<p>Нийтийн тээврийн үйлчилгээний 88 чиглэлд зорчигч урсгалын судалгааг цагийн үечлэлээр, зорилтот зорчигчийн тоо болон 1 тээврийн хэрэгсэл өдөрт тээх зорчигчийн тоог чиглэл тус бүрээр гарган санал боловсруулж, танилцуулга хийсэн. Үүнд:</p> <p>1. Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:1, Ч:7, Ч:24А, Ч:27, Ч:36, Ч:38, Ч:41, Ч:45, Ч:46, Ч:57 чиглэлийн графикийг динамик байдлаар буюу зорилтот зорчигчийн тоо болон тээврийн хэрэгслийн тоог харьцуулсан судалгааг 2 төрлөөр гаргасан. Мөн автобус хоорондын интервалыг өөрчилж, харьцуулсан судалгаа хийсэн.</p> <p>2. Динамик графикийн хүрээнд зохицуулалт хийх боломжтой 4 хувилбар болох тээврийн хэрэгсэл тус бүрээр зорчих зорилтот зорчигчийн тоо, хамгийн их, хамгийн бага эргэлтийн хугацааны залруулгын хувь, жишиг интервал, ажиллах тээврийн хэргслийн тоонд үндэслэн боловсруулах боломжтой үзүүлэлтүүдийг гарган танилцуулсан. Үүнээс зорилтот зорчигчийн тоонд үндэслэн нийт 70 чиглэлд графикийг боловсруулахад өдөрт ажиллах тээврийн хэрэгслийн тоо 12.4 хувиар өсч, ажиллах цаг 4.7 хувь, рейс 7.7 хувиар тус тус буурсан үзүүлэлт гарсан. БНСУ-аас "Улаанбаатар Смарт карт" ХХК-д динамик графикийн програм хөгжүүлэгч ирсэнтэй холбогдуулж хамтарсан уулзалт зохион байгуулж, боловсруулсан графиктай танилцан програмыг бүрэн ашиглаж чадаж байгааг уламжилсан.</p>	
		9.1.1.2 Нийтийн тээврийн үйлчилгээнд динамик графикийг туршиж эхэлнэ.	<p>03 дугаар сарын 29-ний өдрийн өглөөний шуурхай зөвлөгөөнд динамик график боловсруулах 4 хувилбар: 1. Тээврийн хэрэгсэл тус бүрээр зорчих зорилтод зорчигчийн тоо, 2. хамгийн их, хамгийн бага эргэлтийн хугацааны залруулгын хувь, 3. жишиг интервал, 4. ажиллах тээврийн хэрэгслийн тоонд үндэслэн боловсруулах аргачлал, хэрэгжүүлэхэд шаардлагатай тоон мэдээллүүдийг удирдлагуудад танилцуулсан. Зорилтод зорчигчийн тоонд үндэслэн бүх чиглэлд графикийг боловсруулж эргэн танилцуулах үүрэг даалгаврын дагуу Нийтийн тээврийн үйлчилгээний 88 чиглэлд зорчигч урсгалын судалгааг цагийн үечлэлээр, зорилтот зорчигчийн тоо болон 1 тээврийн хэрэгсэл өдөрт тээх зорчигчийн тоог чиглэл тус бүрээр гарган санал боловсруулж, танилцуулга хийсэн. 06 дугаар сарын 06-ны өдрийн Захиргааны зөвлөлийн хурлаар Динамик цагийн хуваарийг эхлүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр санал оруулж хурлын шийдвэрээр: 1. Динамик цагийн хуваарь боловсруулахад зорилтод зорчигчийн тоог</p>	

			<p>тээврийн хэрэгслийн багтаамжаас хамааруулж тогтоох, чиглэл тус бүрийн автобус хоорондын интервалыг чиглэлийн онцлог зорчигч урсгалын хэмжээнээс хамааруулж өдрийн болон оргил ачааллын үед тогтоох, 2. Эцсийн зогсоолд рейс бүрт зогссон цагийн даалгавар, гүйцэтгэлд тооцох эсэх, 3. Динамик графикийг эхлэх хугацаа, туршилтаар хэдэн чиглэлд эхлүүлэх талаар эргэн 33Х-д танилцуулахаар болсон.</p> <p>Динамик графикийг 70 чиглэлд боловсруулсан өдөрт ажиллах тээврийн хэрэгслийн тоо 12.4 хувиар буюу 107-р нэмэгдэх, ажиллах цаг 4.4 хувиар буюу 550 гаруй цагаар, рейс 7.7 хувиар буюу 540-р тус тус буурах, 40 гаруй чиглэлд эргэлтийн хугацаа (3-38 мин) хасагдах, 27 чиглэлд (2-21 мин) нэмэгдэхээр судалгааны дүгнэлт гарсан.</p> <p>Ч:11, Ч:18а, Ч:18б, Ч:16, Ч:30б, Ч:39, Ч:19а, Ч:51 чиглэлүүдэд динамик график туршсан.</p>	
		<p>9.1.1.3 “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</p>	<p>НТЭГ-аас нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг Улаанбаатар смарт карт ХХК нь “Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системээр хэрхэн тооцож байгааг туршин танилцах удирдамж”-ийг батлан програм хөгжүүлэлтийн алдаа зөрчлийг илрүүлэх, илэрсэн алдааг засварлуулах, цаашид системээс гарч буй мэдээ, тайлангийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Ч:59 “ХМК-Офицеруудын ордон” чиглэлд туршилтын ажлыг зохион байгуулж нийтийн тээврийн үйлчилгээний батлагдсан цагийн хуваарь, чиглэл, ажлын гүйцэтгэлийг хэрхэн тооцож байгааг баримтжуулан, илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар хамтран ажилласан.</p> <p>Төслийг хэрэгжүүлэгч Улаанбаатар смарт карт ХХК “Улаанбаатар смарт карт ХХК-ийн 2018 оны төлөвлөгөө”-г 02-р сарын 08-ны өдрийн 2/064 дугаар албан бичгээр ирүүлсэн. Төлөвлөгөөтэй танилцан шаардлагатай ажлуудыг хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системийн цэс хоорондын мэдээлэлд судалгаа хийн холбогдох саналыг гарган Улаанбаатар Смарт Карт ХХК-д 01 дүгээр сарын 29-ний өдөр 2/164 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>НЗДТГазарт төслийг хэрэгжүүлэгч Улаанбаатар смарт карт ХХК-ийн өнөөгийн үйл ажиллагаатай танилцан, Нийслэлийн Засаг дарга болон төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан “Дата карт консорциум”-хооронд 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гэрээ”-ний үүргийн биелэлтийг дүгнэх, ажлын хэсэг шинэчлэн байгуулах хүсэлтийг хүргүүлэн, ажлын хэсэг байгуулах захирамжийн төсөл боловсруулан ажиллаж байна.</p>	

			НЗДТГ-т төслийг хэрэгжүүлэгч Улаанбаатар смарт карт ХХК-иас төслийн хэрэгжилт хэт удаашралтай байгаатай холбоотойгоор 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 3/188 дугаартай албан бичгээр хандсан. 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 3/1096 дугаартай албан бичгээр “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх ажлын хүрээнд дэд системүүдэд тавигдах ерөнхий шаардлагын биелэлтийг хангасан эсэх талаар судалгаа”-г хүргүүлсэн.	
		9.1.1.4 Иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийг хүргэх систем /BIS/-ийг нэвтрүүлнэ.	Нийслэлийн Захирагчийн алба болон НТЭГ-ын дэмжлэгтэйгээр “Хүннү молл” их дэлгүүр, 5 шар, Офицерүүдийн ордоны автобусны зогсоол дээр “Umoney” үйлчилгээний цэгийг туршилтаар нээж лед дэлгэцээр дамжуулан автобусны мэдээллийг түгээх ажлыг эхлүүлсэн. “Улаанбаатар смарт карт” ХХК-ийн зүгээс Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүсэлт гаргасаны дагуу 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/266 дугаар тушаал гарган “U-Money” үйлчилгээний цэгийг нийт 124 байршилд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн мэдээллийг гаргах цахим дэлгэц бүхий /LED/ байгууламжийн бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Нийтийн тээврийн 45 зогсоолд байрших цэгийн байгууламжийг бүрэн угсраад байршуулсан байна. Мөн “UB Smart Bus” гар утасны програмыг Android болон iPhone үйлдлийн системтэй ухаалаг гар утастай хэрэглэгч ашиглах боломжтой талаар сурталчлах ажлыг зохион байгуулж байна.	
		9.1.1.5 Нийтийн тээврийн карт борлуулах цэнэглэх төвүүдийн тоог 100 хүртэл цэгээр нэмэгдүүлж, автомат карт цэнэглэгчийг нэвтрүүлнэ.	Нийслэлийн Захирагчийн алба болон НТЭГ-ын дэмжлэгтэйгээр Улаанбаатар смарт карт ХХК-ийн зүгээс автобусны цахим карт борлуулах, цэнэглэх “Umoney” үйлчилгээний туршилтын цэгийг ашиглалтанд оруулсан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүсэлт гаргасаны дагуу 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/266 дугаар тушаалаар “U-Money” үйлчилгээний цэгийг нийт 124 байршилд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн мэдээллийг гаргах цахим дэлгэц бүхий /LED/ байгууламжийн бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Нийтийн тээврийн 45 зогсоолд байгууламжийг бүрэн угсарч байршуулсан байна. Үндсэн цэнэглэх цэг 432, Юнителийн үйлчилгээний салбараар 61, Мобиком 9, Скайтелын үйлчилгээний салбараар 9, И-Март сүлжээ дэлгүүрээр 2, Номингийн сүлжээ дэлгүүрээр 23, Сиркл К сүлжээ дэлгүүрээр 12 төвөөр үйлчилж байна. Нийт 548 карт цэнэглэх, борлуулах цэг ажиллаж байна.	
		9.1.1.6 Нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийн санг Нийслэлийн хот байгуулалтын	Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх мэдээллийг Нийслэлийн дундын мэдээллийн сангийн серверт байрлуулсан. Нийслэлийн дундын мэдээллийн сан нь иргэдэд нээлттэй болгох, харагдах байдал, өнгө үзэмж	

		дундын мэдээллийн сантай холбоно	талаас засвар хийгдэж байна. 05 дугаар сарын 09-11-ний хооронд холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Орон зайн дундын мэдээллийн санд нийтийн тээврийн 88 чиглэл болон 931 зогсоолын мэдээллийг урьдчилсан байдлаар оруулсан бөгөөд хэрэглэгчдэд зориулсан аппликейшин хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл болон зогсоолын мэдээллийг 2017 онд анх оруулсан бөгөөд чиглэл, зогсоолын өөрчлөлт орох бүрт мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр шинэчилсэн.	
12. Улаанбаатар хотын такси үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ/ 2.5.20				
10.1	10.1.1 Такси үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж ажиллана	10.1.1.1 Гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, парк шинэчлэлийн сангийн хөрөнгө оруулалтаар байгалд ээлтэй шингэрүүлсэн шатдаг хийгээр ажилладаг эсвэл хосолмол цахилгаан хөдөлгүүртэй таксигаар парк шинэчлэлт хийнэ.	Такси үйлчилгээний 9 аж ахуйн нэгж байгууллага өөрийн хөрөнгө оруулалтаар 2018 оны эхний 11 сарын байдлаар 258 таксигаар нөхөн хангалт хийгээд байна. Такси үйлчилгээний 10 аж ахуйн нэгж байгууллагын 628 тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн бүртгэлийн санд бүртгэлтэй байна. Шингэрүүлсэн шатдаг хийгээр ажилладаг эсвэл хосолмол цахилгаан хөдөлгүүртэй 345 такси үйлчилгээнд ажиллаж байна.	
		10.1.1.2 Улаанбаатар такси сервис төслийн хүрээнд таксийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах судалгаа болон таксийн үйлчилгээ эрхлэх орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах судалгааг тус тус хийнэ	1. Улаанбаатар хотын хөгжлийн корпорацаас “Улаанбаатар хотод олон улсын жишигт нийцсэн таксийн үйлчилгээг нэвтрүүлэх” нээлттэй хэлэлцүүлгийг 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт НТЭГ-ын орлогч дарга, холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, таксийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд, иргэдийн төлөөлөл 40 гаруй хүн оролцсон. 2.“Такси үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд” сэдвээр 03 дугаар сарын 01, 20-ний өдрүүдэд “Стар” телевизийн хэлэлцүүлэг нэвтрүүлэгт, “Дэлхийн томоохон хотуудын такси үйлчилгээний чиг хандлага” сэдвээр Монголын үндэсний радиогийн шууд нэвтрүүлэгүүдэд “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК болон таксийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, жолооч нарын хамт оролцож, такси үйлчилгээний эрх зүйн орчныг өөрчлөх, шинэчлэх боломж, чиг хандлага, таксийн үйлчилгээ эрхлэх төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн талаар иргэд олон нийтэд мэдээлэл өгсөн. 3. НЗД-ын 03 дугаар сарын 02-ны өдрийн А/193 дугаар Улаанбаатар хотод такси үйлчилгээ эрхлэх нөхцөл, боломжийг сайжруулах, холбогдох стандарт, дүрэм журмыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамж гарсан.	
		10.1.1.3 Нийслэлийн хөрөнгө	05 дугаар сарын 15-ны өдрийн 1/645 тоот албан бичгээр нийслэлийн газар	

		<p>оруулалтаар байгуулагдсан таксийн зогсоолын тоог нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллага, хэлтэстэй хамтран ажиллана</p>	<p>зохион байгуулалтын төлөвлөгөөнд таксийн 9 зогсоолын газрыг тусгуулах саналаа нийслэлийн Газрын албанд хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцооллыг боловсруулсан.</p> <p>Авто зам сэтэлгээ, орц гарцын зөвшөөрөл олгох ажлын хэсгийн 2018 оны 09 сарын 25-ны өдрийн хуралдаанаар Макс группээс Цамбагарав худалдааны төвийн таксийн зогсоолын зориулалтыг өөрчлөн төлбөртэй зогсоол болгох талаар танилцуулга хийсэн. Танилцуулгад байгууллагын саналын төсөл боловсруулж, “зөвшөөрөх боломжгүй” гэх тус газрын саналыг Улаанбаатар хотын НЗААлбаны дарга, Нийслэлийн Авто зам хөгжлийн газарт албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Иргэдийн гомдлын дагуу Таксийн зогсоолуудад биечлэн шалгаж, Зайсан орчмын таксийн зогсоолд такси жолоочийн хувийн харилцаанаас үүдэлтэй хэд хэдэн зөрчил илэрсэний дагуу холбогдох удирдлагуудад зохих шаардлагыг утсаар мэдэгдэж ажилласан.</p> <p>Драгон төвийн захирал, Автотээврийн үндэсний төвийн удирдлагууд, тус газрын холбогдох албан тушаалтан, Улаанбаатар такси ХХК-ийн удирдлагатай уулзан Драгон төвийн автомашины зогсоолд такси зогсоол байгуулахаар хэлэлцсэн. Өнөөдрийн байдлаар драгон төв нь такси зогсоолын зай талбай гарган өгч ажиллахад бэлэн байгаагаа мэдэгдсэн. Улаанбаатар такси ХХК нь тусгаарласан хашлага барихаар төлөвлөөд байна.</p>	
13. Төмөр замын сүлжээг хотын нийтийн тээвэрт ашиглана. / 2.5.21				
11.1	13.1.1 Төмөр замын үйлчилгээтэй нийтийн тээврийг уялдуулах зорилгоор "Улаанбаатар Төмөр зам" ХНН-тэй хамтран ажиллана.	13.1.1.1 Хамтарсан ажлын хэсэг байгуулна	<p>Төмөр замын тээврийг нийтийн тээврийн үйлчилгээтэй уялдуулах асуудлаар мэдээлэл авах зорилгоор 2018 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар төмөр зам ХНН-ын хэлтсийн даргатай уулзалт хийсэн. Уулзалтаар Рейлбусын цагийн хуваарь, 1 рейсэнд зарцуулах хугацаа, эдийн засгийн тооцоолол, зорчигч урсгалын судалгааны талаар тодорхой мэдээлэл авсан.</p> <p>Төмөр замын тээврийн нийтийн тээврийн үйлчилгээтэй уялдуулах талаар ажлын хэсэгт Нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүүд Төмөр зам буюу Рейлбусыг хот доторх нийтийн тээврийн үйлчилгээтэй уялдуулах талаар төлөвлөлтийн санал боловсруулан танилцуулга бэлтгэж 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдөр танилцуулсан. /Ажлын хэсэг нийслэлд байгуулагдсан/</p>	
		13.1.1.2 Төмөр замын терминалыг нийтийн тээврийн үйлчилгээний	Төмөр замын терминалыг нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолтой уялдуулах талаар санал боловсруулж танилцуулга бэлтгэн нийслэлийн	

		зогсоолтой уялдуулах талаар санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Засаг даргын орлогч П.Баярхүүд танилцуулсан. Мөн Төмөр замын терминалыг нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолтой уялдуулах талаар санал боловсруулж Улаанбаатар төмөр зам ХНН-рүү 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 2/1223 тоот албан бичгээр хүргүүлсэн. Дээрх албан бичгийн дагуу Улаанбаатар төмөр зам ХНН-тэй уулзалт зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган холбогдох судалгааны ажлуудыг хийж танилцуулахаар бэлтгэж байна.	
14. Сургуулийн бүсэд аюулгүй байдлыг бүрэн хангасан стандарт нэвтрүүлж, сурагчдыг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих асуудлыг шийдвэрлэх хүрээнд "Сургуулийн автобус" төсөл хэрэгжүүлнэ.. /4.1.8. /ЗГҮАТ-ийн 3.2.4 дахь заалт/				
14.1	14.1.1 Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нийтийн тээврээр сургуульдаа ирэх, буцах зорчилттой холбоотой судалгааг хийж цахим мэдээллийн сан үүсгэнэ.	14.1.1.1 Нийтийн тээврийн хэрэгслээр сургуульдаа ирж очдог сурагчдын судалгааг гаргаж, сургуулийн автобус явуулах зайлшгүй шаардлагатай сургуулийг тодорхойлж холбогдох байгууллагуудад санал хүргүүлнэ.	<p>"Хүүхэд хамгаалал" хэсэгчилсэн арга хэмжээний үеэр тус газраас авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд НЦГ болон НБГ-тай хамтран ерөнхий боловсролын 3 дугаар ээлжээр хичээллэдэг нийт 7 сургуульд 10 аж ахуйн нэгжийн 13 чиглэлд 13 тээврийн хэрэгслийг ажиллуулахаар төлөвлөн 02 дугаар сарын 05-ны өдрөөс 14-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилсэн. Дээрх өдрүүдэд давхардсан тоогоор нийт 56 автобус ажиллаж 1431 сурагчийг тээвэрлэсэн.</p> <p>Хүүхэд хамгаалал арга хэмжээний хүрээнд нийслэлийн хэмжээнд 3 дугаар ээлжээр хичээллэж буй сургуулийн сурагчдыг тээвэрлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн цаашид сургуулийн автобус үйлчлэх шаардлагатай чиглэлүүдийн мэдээллийг нэгтгэн холбогдох төлөвлөлтийг боловсруулан зардлын тооцоог гаргуулан Нийслэлийн орлогч Ш.Анхмаад 2/699 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Ерөнхий боловсролын 96 сургуулийн хамран сурах тойргийн бус 31730 сурагчдын судалгааг цугларсан мэдээллийн хүрээнд нэгтгэж боловсруулсан. Судалгаанд хамрагдсан сурагчдын 85.8% нь сургуульдаа ирж, буцахдаа нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлдэг ба дунджаар 3.9 км зайнаас сургуульдаа ирж буцдаг байна.</p> <p>Нийслэлийн Боловсролын газартай хамтран сургуулийн автобус шаардлагатай сургуулиудын судалгааг авч байгаа бөгөөд судалгааны дүн нэгтгэгдэн ирсэн тохиолдолд сурагчийн автобусны төлөвлөлтийг боловсруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн өглөө оройн оргил ачааллын үеэр Энхтайваны өргөн чөлөө дагуу нийтийн тээврийн хэрэгслээр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг тээвэрлэх нэмэлт автобус ажиллуулах талаар холбогдох тооцоо судалгааг хийж төлөвлөлтийг боловсруулан арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>2018 онд иргэдээс ирсэн санал хүсэлт, иргэдийн зорчих эрэлттэй уялдуулан нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарийг иргэдэд хүртээмжтэй байхаар төлөвлөсөн. Үүнд:</p> <p>-Нийтийн тээврийн үйлчилгээний өглөөний оргил ачааллын 7:10, 7:25</p>	

			цагуудад богино эргэлтийн 8 чиглэлд, оройн оргил ачааллын 18:20 цагт богино эргэлтийн 9 чиглэлд тус бүр нэг автобус Түр зохицуулалтаар 12 дугаар сарын 10-21-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилсэн. - Хот орчмын болон алслагдсан 16 чиглэлд өглөөний эх авах цагийг 5-9 минутаар урагшлуулах зохицуулалт хийсэн. - Ачаалал ихтэй Ч:8, Ч:27, Ч:41, Ч:42, Ч:65 автобуснуудын тоог нэмэгдүүлсэн. - Хэт хол буюу 50 км-с дээш урттай зарим чиглэлийг богиносгон хүлээгдлийн хугацааг багасгаж, өдөрт үйлчлэх давтамжийг нэмэгдүүлж, давхацлыг бууруулах ажлын хүрээнд Ч:65 "Зайсан-Офицеруудын ордон", Ч:66 "Зайсан-Цэцэг төв-11-р хороолол" чиглэлүүдийг шинээр төлөвлөн хийсэн.	
		14.1.1.2 Судалгаанд үндэслэн сурагчдыг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих нөхөн олговрын тооцоо судалгааг гаргаж салбарын яаманд хүргүүлнэ.	Хүүхэд хамгаалал арга хэмжээний хүрээнд нийслэлийн хэмжээнд гурван ээлжээр хичээллэж буй сургуулийн сурагчдыг тээвэрлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн цаашид үйлчлэх шаардлагатай 107, 65, 44, Амгалан цогцолбор сургуулиудын автобусны чиглэлүүдийн мэдээллийг нэгтгэн холбогдох төлөвлөлтийг боловсруулсны дагуу зардлын тооцоог хийн Нийслэлийн орлогч Ш.Анхмаад 2/699 тоот албан бичгээр хүргүүлсэн. НӨХГ-аас томилсон "Экологбус" ХХК-аас нийлүүлж буй сургуулийн автобус хүлээн авах "Хөрөнгө хүлээн авах комисс"-т ажилласан. "Экологбус" ХХК нь хүүхдийн зориулалттай угсарсан J-800B загварын сургуулийн автобусыг Хан-Уул дүүргийн 59-р сургууль, Налайх дүүргийн 109-р сургууль, СХД-ийн алслагдсан 21-р хорооны 74-р сургуульд хүлээлгэн өгсөн.	
		14.1.1.3 Стандартын шаардлага хангасан хүүхдийн автобусанд журмын хүрээнд зөвшөөрөл олгож ажиллана.	Нийслэлийн боловсролын газарт 2018 оны 01 дүгээр сарын 15-наас 17-ны өдрүүдэд нийтийн тээврийн газрын техник хяналтын хаврын оношлогоонд зөвшөөрөлтэй сургуулиудын тээврийн хэрэгслүүдийг хамруулах талаар 2018.01.12-ны өдрийн 3/66 тоот албан бичиг хүргүүлсэн. "Экологбус" ХХК нь хүүхдийн зориулалттай угсарсан J-800B загварын сургуулийн автобусыг Хан-Уул дүүргийн 59-р сургууль, Налайх дүүргийн 109-р сургууль, Сонгинохайрхан дүүргийн алслагдсан 21-р хорооны 74-р сургуульд хүлээлгэн өгсөн. 1. НИТХ-ын 2012 оны 2/08, 4/14 тоот тогтоолууд, НТЭГ-ын 2017 оны А/83 дугаар тушаалын хүрээнд 05 дугаар сарын 31-ний байдлаар хүүхдийн автобусны 2 ААНэгжийн 3 тээврийн хэрэгслийг АТХУБайцаагчийн дүгнэлтийг үндэслэн бүртгэлийн санд бүртгэж, нэгдүгээр эгнээгээр зорчуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтарч зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага болон Замын хөдөлгөөний Удирдлагын төвд албан тоотоор хүргүүлсэн.	

			<p>Нийт бүртгэлийн санд Хүүхдийн автобус 14 аж ахуйн нэгж байгууллагын 24 тээврийн хэрэгсэл, ажилчдын 46 аж ахуйн нэгж байгууллагын 80 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.</p> <p>2. 2018-2019 оны хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан нийслэлийн Тээврийн газар, Замын цагдаагийн алба, нийслэлийн Боловсролын газартай хамтран “Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд тавигдах шаардлага” MNS 6440:2014 стандарт, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага.” MNS 4598:2011стандартын хэрэгжилтийг хангасан байдалд хяналт тавих нэгдсэн үзлэг, шалгалтыг 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс 17-ны өдрүүдэд, мөн сургуулиудаас ирсэн хүсэлтийн дагуу 30, 31-ний өдрүүдэд нийслэлийн Тээврийн газрын техникийн үзлэг оношилгооны төв дээр явууллаа. Шалгалтад Нийслэлийн 7 дүүргийн 39 сургуулийн нийт 72 автобус хамрагдсанаас 23 сургуулийн 46 автобус тэнцсэн тул үйлчилгээнд явах зөвшөөрлийг нь олгосон.</p> <p>2018 оны 11 сарын байдлаар хүүхдийн автобусны 29 аж ахуйн нэгж, байгууллагын 63, тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгогдсон байна.</p>	
		<p>14.1.1.4 Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэх, автозамын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээгээр зорчуулах улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх журмыг шинэчилнэ</p>	<p>НТЭГ-ын 2017 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэх, авто замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээгээр зорчуулах, улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх” журмыг шинэчлэн боловсруулсан. Газрын даргын 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/28 дугаар тушаалаар шинэчилсэн журмыг батлуулан мөрдөн ажиллаж байна.</p>	
ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ОНОО				

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин		Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)	Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ
1	2	3	4
<p>1.Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Зорилт-1: Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана. Зорилт-2: Төрийн захиргааны албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлнэ.</p>	<p>а) Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Ёс зүйн хорооны үйл ажиллагааг хууль дүрмийн дагуу явуулж хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлж ажиллах</p>	<p>а) НТЭГ-ын нийт 35 ХАСХОМ мэдүүлэгчийн тайланг Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу 35 ХАСХОМ мэдүүлэгчийн ХАСХОМ-1 хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн тайлан, ХАСХОМ-2 буюу хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт НЗД-ын Тамгын газарт 02 дугаар сарын 09-ний өдрийн 1/219 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Байгууллагын эрх бүхий албан тушаалтан ХАСХОМ-ын сургалтыг 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, ТЗ-6 ба түүнээс дээш зэрэгтэй 30 албан хаагч хамрагдсан. - Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбогдуулан хууль зөрчигчдөд хэрхэн хариуцлага тооцох, мэдээ тайлан, хавтаст хэрэг хэрхэн үүсгэх эрх, баримт бичгийн талаар Нийслэлийн Прокурорын газраас прокурор н.Мэндсайхан, н.Ганцэцэг нар 02 дугаар сарын 28-ны өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтад байгууллагын нийт Автотээврийн хяналтын улсын байцаагч нар хамрагдсан. Мөн НЗДТГ-аас 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/839 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газраас 2017 онд төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад явуулсан төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудлаар гаргасан зөвлөмжийг хүлээн авч зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан. Авлигатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс НЗД-ын 2018 оны А/237 дугаар захирамжаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх “2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсаны дагуу тус газар нь дотооддоо 05 дугаар сард “Нийслэлийн тээврийн газрын 2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г шинэчлэн батлуулж, мөрдүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар: 100%-6,</p>	

		<p>80%-3, 70%-1, нийт 91% байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй авлигын эсрэг мэдлэг олгох сургалтад тус газраас төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2018 оны 10 дугаар сарын 26, 11 дүгээр сарын 13-ны өдрүүдэд 11 албан тушаалтнууд хамрагдлаа.</p> <p>Монгол улсын Авилгатай тэмцэх газар, Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсээс 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан “Төрийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн сургалт”-д тус газрын эрх зүйч оролцож, холбогдох мэдээлэл авсан.</p> <p>Мөн авлигын эсрэг сурталчилгааг хэрэгжүүлэх “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 11 дүгээр сарын 29-ний өдөр нийслэлийн Тээврийн газар, Авилгатай тэмцэх газар, “Улаанбаатар смарт карт” ХХК нар байгуулав.</p> <p>Уг санамж бичгийн хүрээнд нийтийн тээврийн үндсэн чиглэлийн автобуснуудад авилгын эсрэг зурагт хуудас, мэдээллийг байршуулах, U money цахим карт дээр авилгын эсрэг сурталчилгааг хэвлүүлэх, буудал зарлагч цахим дэлгэцээр авлигыг мэдээлэл 18001969 дугаарын утсыг сурталчлах зэрэг ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>б) Төлөвлөгөөний дагуу газрын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сайжруулах үүрэг бүхий ёс зүйн хороо болон түүний мөрдөх дүрмийн төслийг боловсруулан Авлигатай тэмцэх газраас санал авч газрын даргын 03 дугаар сарын А/20 дугаар тушаалаар “Нийслэлийн Тээврийн газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон Ёс зүйн хэм хэмжээний зөрчлийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын, орон тооны бус хороог байгуулсан.</p>	
<p>2.Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Төрийн байгууллагын цахим хуудсын стандартыг дагаж мөрдүүлнэ.</p> <p>Зорилт-2: Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг мөрдүүлнэ</p>	<p>а) Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын цахим хуудсын стандартын дагуу хөгжүүлэн, хууль журамд заасан мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэх</p> <p>б) Шилэн дансны</p>	<p>а) Тээврийн салбарын үйл ажиллагаа мэдээ, мэдээллийг https://www.facebook.com/transport.ub.gov.mn/ цахим хуудсанд байршуулан ажиллаж байсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 138 дугаар “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” тогтоол батлагдан гарсан. Тогтоолыг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан бүх албан хаагчдыг мэдээллээр хангасан. нийслэлийн Мэдээллийн технологийн газартай холбогдон тус газрын хэмжээнд ашиглагдаж байгаа олон нийтийн сүлжээ facebook, youtube, twitter гэх мэт сайтуудад нэвтрэх боломжийг хаалгаж тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Байгууллагын ажилтан албан хаагчдад зориулагдсан мэдээ, мэдээллүүд, даргын тушаал, үүрэг даалгавар, ажилтан, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүдийг www.transport.ub.gov.mn сайтад байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна.</p>	

	<p>www.shilendans.gov.mn www.ub-procurement.mn сайтад мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулах</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 06/4670 дугаар албан бичгийн дагуу 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “UB ERP” дотоод удирдлагын системийг нэвтрүүлэн ашиглах болсонтой холбогдуулан 3 удаа сургалтыг албан хаагчдад хийсэн. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг дээрх системээр бүртгэж, шийдвэрлэж байна.</p> <p>б) Газрын даргын 2018 оны А/17 дугаар тушаалаар "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын дагуу шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулах албан тушаалтнуудын хуваарь батлагдсан.</p> <p>Уг хуваарийн дагуу шилэн дансны www.shilendans.gov.mn, www.ub-procurement.mn сайтад мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулан ажиллаж байна.</p> <p>Газрын 2018 оны баталсан төсөв, нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих ахмад настан, цагдаа, сурагч, оюутны унааны зардлын 2018 оны нөхөн олговрын төсөв, 2018 оны 1-12 сарын хуваарилалт, төсвийн гүйцэтгэлийн тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p>	
<p>3.Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Байгууллагын санхүүгийн тайланд аудит, дотоод аудит хийнэ Зорилт-2: Байгууллагын батлагдсан төсөв, нэмэлт өөрчлөлтийг ил тод мэдээлнэ</p>	<p>а) Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж мэдээлж ажиллах б) Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ бусад санхүүгийн холбогдох мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах в) Нийтийн тээврийн үйлчилгээний нөхөн олговрын хуваарилалтыг байгууллагын цахим хуудсанд байршуулах</p>	<p>а) Байгууллагын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын цахим www.http//transport.ub.gov.mn/ хуудсанд байрлуулсан.</p> <p>НТЭГ-ын үйл ажиллагаанд хийсэн аудит, хяналт шалгалтын байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмжийг судлаж, тус газрын 2016 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит, хяналт шалгалт хийсэн шалгалтаар илэрсэн асуудлын хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргасан.</p> <p>Нийт 42 арга хэмжээний хэрэгжилт 100%-21, 90%-4, 70%-2, 50%-4, 30%-6,10%-2, 0%-3 3000/4200 хэрэгжилт 71,4 %-тай байна. НАГ-т 6 дугаар сарын 20-ны өдрийн 1/891 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 100%-25, 90%-4, 70%-1, 50%-6, 30%-4,10%-1, 0%-1 3360/4200 хэрэгжилт 80%-тай байна.</p> <p>Тус газрын 2017 оны санхүүгийн тайланд Бэст фортуна аудитын багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл гарган холбогдох хэлтэс, албан хаагчдаас санал авч төлөвлөгөөг батлуулсан.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 50%-тай байна. /2-100%, 1-70%, 7-50%, 1-30%, 2-0%, хугацаа болоогүй 5/ Тайланг 07 дугаар сарын 4-ний 1/896 тоот албан бичгээр НЗДТГ-н Санхүү, төрийн сангийн хэлтэст, 1/897 тоотоор НАГ-т, 1/898 тоотоор Бэст Фортуна ХХК-д тус тус хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилт 3 улирлын байдлаар 63,1%-тай байна. /3-100%, 1-</p>	

		<p>90%, 5-70%, 1-50%, 1-30%, 2-0%, хугацаа болоогүй 5/12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар: Нийт 18 арга хэмжээний 10-100%, 1-90%, 1-70%, 1-30%, 5-0% дундаж 1190/1800 Хэрэгжилт 66,1%-тай байна.</p> <p>в) НТЭГ-ын 2018 оны баталсан төсөв, нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих ахмад настан, цагдаа, сурагч, оюутны унааны зардлын 2018 оны нөхөн олговрын төсөв, 2018 оны 1-12 сарын хуваарилалт, төсвийн гүйцэтгэлийн тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p>	
<p>4.Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт-1: Байгууллагын эд хөрөнгө ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллана Зорилт-2: Ил тод, шударга, хэмнэлттэй байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлана.</p>	<p>а) Байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах. б) Эд хөрөнгийн тооллого, тооцоо, бүртгэлийг үнэн зөв, чанартай хийх. в) Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайланг тухай бүр цахим хуудаст байршуулах.</p>	<p>а) Байгууллагын хөрөнгийн ашиглалтыг сайжруулан, чанаржуулан эд хөрөнгийн бүртгэлийг үнэн зөв чанартай хийн ажиллаж байна.</p> <p>б) НТЭГ-ын 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/37 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн хагас жилийн хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулах тухай” тушаал батлагдсан. Тооллогын комиссын хурал, Техникийн болон өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд оруулан 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 33Х-д танилцуулан нийт дүнгээр 53 нэр төрлийн 8850990 төгрөг 63 мөнгөний үндсэн болон эргэлтийн хөрөнгө актлах саналыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Тооллогоор: Эргэлтийн бус хөрөнгийн 39000 тоот дансны нийт дүн 664 нэр төрлийн 3,288,077,197 төгрөг 13 мөнгө Эргэлтийн хөрөнгийн 35000 тоот дансны нийт дүн 773 нэр төрлийн 69,423,396 төгрөг 00 мөнгө, байгууллагын нийт дүнгээр 1437 нэр төрлийн 3,357,500,593 төгрөг 13 мөнгөний эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө байна.</p> <p>НТЭГ-ын 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/55 дугаар “Эргэлтийн хөрөнгө данснаас хасах тухай” тушаал батлагдсаны дагуу устгалын комисс ажиллаж эргэлтийн хөрөнгийг данснаас хассан. НӨХГ-т эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлээс хасч актлах зөвшөөрөл хүссэн албан бичгийг 6 дугаар сарын 29-ний өдрийн 1/863 тоотоор хүргүүлсэний дагуу НӨХГ-с ирж хөрөнгийг үзэн хянаж НӨХГ-н даргын 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/468 тоот “Нийслэлийн Тээврийн газрын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай” тушаалаар нийт 8288691,63 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг актлаж данс бүртгэлээс хасахыг зөвшөөрсөн. Үүний 5 нэрийн 769 900 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг журмын дагуу устгахаар, 26 нэрийн 7518791,63 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг ӨХГ-т актаар хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэж хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/90 дүгээр тушаал гарч 2018 оны жилийн эцсийн тооллого хийгдэж байна.</p> <p>в) 2018 оны байдлаар төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан аваагүй болно.</p>	
<p>5.Байгууллагын хүний нөөцийн</p>		<p>а) 2015-2019 онд Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах</p>	

<p>чадавхийг бэхжүүлэх талаар: Зорилт-1: Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангана. Зорилт-2: Хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийн ил тод нээлттэй байдлыг хангана</p>	<p>а) Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангах б) Сул орон тооны зарыг олон нийтийн хэрэгсэл, сайтад нээлттэй зарласан байх. в) Албан хаагчдыг сургалтанд хамруулах.</p>	<p>төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. б) Төрийн жинхэнэ албан тушаалын 2 сул орон тоонд Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлуулах хүсэлтийг 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/340 дүгээр албан бичгээр Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 04 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн албаны мэргэшлийн шалгалт зарлан, шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авч шалгарсан Д.Мөнхсарнайг Салбарын сургалт хариуцсан мэргэжилтнээр 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/60 дугаар тушаалаар, Э.Энхзулыг Эдийн засаг судалгааны мэргэжилтнээр 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/58 дугаар тушаалаар тус тус томилов. Мөн Дотоод ажил, гадаад харилцаа, хуралдаан хариуцсан мэргэжилтний 1 сул орон тоо гарсан тул нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 05 дугаар сарын 29-ний өдрийн 1/708 дугаар албан бичгээр иргэн Ц.Базаррагчааг нэр дэвшүүлсэн хүсэлт хүргүүлж, 06 дугаар сарын 05-ны өдрийн 14/258 дугаар албан бичгээр тус албан тушаалд иргэн Ц.Базаррагчааг томилохыг зөвшөөрсөн тул 06 дугаар сарын 07-ны өдрийн Б/71 дүгээр тушаалаар томилоод байна. НТЭГ-ын орлогч дарга, зохион байгуулалтын нэгжийн дарга нарын орон тоог төрийн жинхэнэ албан хаагчдаас албан тушаал дэвшүүлэх замаар нөхөх саналыг нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалт хийгдэн төрийн жинхэнэ 4 албан хаагчдыг удирдах албан тушаалд томилов. 2018 оны байдлаар нийт 21 сургалтад давхардсан тоогоор 117 албан хаагч хамрагдаад байна.</p>	
<p>Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>			

Тайлан бичсэн:

Төсвийн шууд захирагч

НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГА ДОРЖСҮРЭНГИЙН ОТГОНБААТАР

.....
(огноо)

Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН

.....
(огноо)

Төсвийн шууд захирагчийн хүлээх хариуцлагын хувьд

1.5	<p>Үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Тайлант хугацаанд НТЭГ-т Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол 3, Нийслэлийн Засаг даргын захирамж 23, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 7, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал 1, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн зөвлөмж 1, Нийслэлийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоол 5 тус тус ирсэн. Тус газраас өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
1.6	<p>Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд дагаж мөрдөнө.</p>	<p>НТЭГ-ын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сайжруулах үүрэг бүхий ёс зүйн хороо болон түүний мөрдөх дүрмийн төслийг боловсруулан Авлигатай тэмцэх газраас санал авч газрын даргын 03 дугаар сарын А/20 дугаар тушаалаар “Нийслэлийн Тээврийн газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон Ёс зүйн хэм хэмжээний зөрчлийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын, орон тооны бус хороог байгуулсан.</p>
1.7	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын баримт бичгийн уялдаа холбоог хангаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны “Аз жаргалтай хот” хөтөлбөр, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хөтөлбөрийн биелэлтийг асуудал хариуцсан орлогчид тайлагнаж, үр дүнг Засаг даргын өмнө хариуцна.</p>	<p>Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны “Аз жаргалтай хот” хөтөлбөр, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтэд хяналт тавин, хэрэгжилтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүүд тайлагнан ажиллаж байна.</p>
1.8	<p>Улаанбаатар хотын “Аз жаргалтай хот индекс”-ийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан ажиллана.</p>	<p>“Аз жаргалтай хотын индекс”-ийн шалгуур үзүүлэлтийг хангах ажлын хүрээнд нийтийн тээврийн автобусны хүлээгдлийн хугацаа 2018 оны 03 дугаар улирлын байдлаар 8,1 минут байна. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр: “автобусны хүлээгдлийн хугацааг байгаа түвшингээс нэмэгдүүлэхгүй байх” зорилтыг хангаж ажилласан байна. Улаанбаатар хотын “Аз жаргалтай хотын индекс”-ийн шалгуур үзүүлэлтэд тусгах саналаа НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэст цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлсэн. 03 дугаар сарын 21-ний өдөр НЗДТГ-ын БТХ-ээс “Агентлагийн чиг үүрэг болон үзүүлэлт тодорхойлох” сургалтад тус газрын холбогдох мэргэжилтэн хамрагдсан. Энэ онд шинээр хийгдэх нийтийн тээврийн 50 зогсоолын жагсаалтыг Жэй Си Дэко ХХК-тай хамтран гаргасан. 2018 оны 09 дүгээр сарын 31-ний өдөр 50 байршилд дэлхий стандартад нийцсэн автобусны зогсоолын байгууламжийг угсарч дууссан. 10 дугаар сарын 01-ний өдөр Жэй Си Дэко Монголиа ХХК-ны техникийн ахлах ажилтантай хамтран 50 зогсоолыг шалгасан. Барилга байгууламжийг хүлээж авахаар</p>

		бэлтгэл ажил хангагдаад байна.
1.9	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлүүлнэ.	Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны шугамын гүйцэтгэл 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дундаж гүйцэтгэл 96,8 хувь байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0,5%-иар илүү байна. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр: "автобусны шугамын гүйцэтгэлийг 90 хувиас доош бууруулахгүй ажиллана" зорилтын үнэлгээг хангаж ажилласан байна.
1.10	2018 оныг "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил" болгон зарласантай холбогдуулан энэхүү ажлын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллана.	"Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/86 дугаар захирамжаар батлагдсан "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус газрын чиг үүрэгт хамааралтай 2 ажил тусгагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/418, 06 дугаар сарын 07-ны өдрийн 1/756, 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/1321, 12 дугаар сарын 17-ны өдрийн 1/1565 тоот албан бичгүүдийн хамт хавсралтаар тус тус нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажиллав. Нийслэлийн 2018 оныг "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил" болгосонтой уялдуулан нийтийн тээврийн салбарын хүрээнд 2018 оныг "Иргэдийн оролцоотой тээвэрлэлтийн нөхцөлийг сайжруулах жил" болгон зарлаж тус газрын 2018 оны А/16 дугаар тушаалаар "Ажлын хэсэг" байгуулж, нийт хэрэгжүүлэх 27 ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт: 100%-17, 90%-4, 85%-2, 80%-3, хэрэгжилтийн дундаж 91,4% байна.
1.11	Байгууллагын хэмжээнд тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай асуудлаар 2-оос доошгүй ажлыг санаачилж хэрэгжүүлэн ажиллана.	"Сар шинийн баярын өдрүүдэд буюу 02 дугаар сарын 16,17,18-ны өдрүүдэд нийтийн тээврийн үндсэн, хот орчмын, шөнийн тээврийн үйлчилгээний их, дунд багтаамжийн автобус, троллейбуснууд иргэдэд "ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ" үйлчилсэн. 01 дүгээр сарын 09-ний өдөр ЗТХ-ийн сайдын 06 дугаар тушаалаар байгуулагдсан ЗТХ-ийн сайд болон НЗД нарын 2016-2020 онд Зам тээврийн салбарт хамтарч ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2018-2020 онд хамтарч ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийн нэгдүгээр хуралд оролцож, "Санамж бичиг"-т оруулах өөрчлөлтөд өгөх саналыг хэлтсүүдээс нэгтгэн авч 01 дүгээр сарын 18-ны өдөр ЗАА болон ЗТХЯ-нд тус тус хүргүүлэв. 02 дугаар сарын 02-ны өдөр ЗТХЯ дээр ЗТХЯ, Нийслэлийн хамтарсан ажлын хэсгийн 2-р хуралд орлогч дарга болон холбогдох мэргэжилтнүүд оролцсон. Ажлын хэсгийг ЗТХЯ-аас Цогтбаяр дэд сайд, НЗД-ын орлогч нар ахалж 05 дугаар сард Санамж бичигт өөрчлөлт оруулж баталсан. 2018 оны 03, 05 дугаар саруудад нийслэлийн Захирагчийн алба болон тус газрын дэмжлэгтэйгээр Улаанбаатар смарт карт ХХК-ийн зүгээс "Хүннү молл" их дэлгүүр, 5 шар, Офицерүүдийн ордоны автобусны зогсоол дээр "Umoney" үйчилгээний туршилтын цэгийг нээснээрээ лед дэлгэцээр дамжуулан ойртон ирж байгаа автобусны мэдээллийг түгээх ажлын эхлэлийг тавьсан. 2018 онд иргэдээс ирсэн санал хүсэлт, иргэдийн зорчих эрэлттэй уялдуулан нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарийг иргэдэд хүртээмжтэй байхаар төлөвлөсөн.

		<p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Нийтийн тээврийн үйлчилгээний өглөөний оргил ачааллын 7:10, 7:25 цагуудад богино эргэлтийн 8 чиглэлд, оройн оргил ачааллын 18:20 цагт богино эргэлтийн 9 чиглэлд тус бүр нэг автобус Түр зохицуулалтаар 12 дугаар сарын 10-21-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилсэн. - Хот орчмын болон алслагдсан 16 чиглэлд өглөөний эх авах цагийг 5-9 минутаар урагшлуулах зохицуулалт хийсэн. - Ачаалал ихтэй Ч:8, Ч:27, Ч:41, Ч:42, Ч:65 автобуснуудын тоог нэмэгдүүлсэн. - Хэт хол буюу 50 км-с дээш урттай зарим чиглэлийг богиносгон хүлээгдлийн хугацааг багасгаж, өдөрт үйлчлэх давтамжийг нэмэгдүүлж, давхацлыг бууруулах ажлын хүрээнд Ч:65 "Зайсан-Офицеруудын ордон", Ч:66 "Зайсан-Цэцэг төв-11-р хороолол" чиглэлүүдийг шинээр төлөвлөн хийсэн.
1.12	Нийслэлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх арга замаар хэрэгжүүлнэ.	<p>а) БНСУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Нийтийн тээврийн үйлчилгээний паркийг байгалийн шахсан хийн хэрэглээ бүхий 1000 автобусаар шинэчлэх төсөл" хэрэгжүүлэхээр холбогдох мэдээллийг гаргаж 2018 оны 03 дугаар сарын 03-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>БНСУ-ын талаас төслийг судлан үзэж нэмэлт, тодруулах мэдээлэл шаардсаны дагуу 5 дугаар сарын 21-ний өдөр төсөлтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргаж өгсөн. Төсөл хэрэгжсэн тохиолдолд 2018-2019 онд 2 үе шаттайгаар 200,0 сая ам доллар 481,1 тэрбум төгрөгийн зээл авах юм. БНСУ-ын Экспорт-Импорт банкны ажлын хэсгийн төлөөлөгчидтэй 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдөр уулзаж, 400 автобусаар парк шинэчлэх шаардлагатай байгааг уламжилж, эдгээрийн 200 автобусыг байгалийн шахсан хийн хөдөлгүүртэй, 200 автобусыг евро-5 хөдөлгүүртэй байх санал тавьж, шаардлагатай нэмэлт тодруулга, мэдээллийг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн.</p> <p>б) Нийтийн тээвэрт парк шинэчлэлтийн хүрээнд: 2018 оны эхний 11 сарын байдлаар үндсэн чиглэлийн 16 аж ахуйн нэгж, байгууллага 145 их багтаамжийн автобусаар парк шинэчлэлт, нөхөн хангалт хийж 19 аж ахуйн нэгж байгууллагын 1207 тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн бүртгэлийн санд бүртгэлтэй. Урд оны мөн үетэй харьцуулахад 5 тээврийн хэрэгслээр буурсан дүнтэй.</p>
1.13	2017 оны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд шалган зааварчилсан ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжид тусгагдсан ажлуудыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хагас бүтэн жилийн тайлангийн хамт үр дүнг үнэлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст ирүүлнэ.	НТЭГ-ын 2017 оны үйл ажиллагаанд шалган, зааварласан ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэлтэс, нэгжүүдэд өгч, биелэлтийг 2018 оны эхний хагас жилийн байдлаар гарган 06 дугаар сарын 25-ны өдрийн 1/845, жилийн эцсийн байдлаар 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/1617 тоот албан бичгийн хамт тус тус хавсралтаар НЗДТГ-ын ХШҮХэлтэст хүргүүлэв.
1.14	Албан үүргээ гүйцэтгэхдээ нэгдмэл сонирхолтой болон хамаарал бүхий этгээдтэй холбоотойгоор олон нийтэд	Албан үүргээ гүйцэтгэхдээ нэгдмэл сонирхолтой болон хамаарал бүхий этгээдтэй холбоотойгоор олон нийтэд төрийн албан хаагч, төрийн албанд эргэлзээ төрүүлэх,

	<p>төрийн албан хаагч, төрийн албанд эргэлзээ төрүүлэх, итгэлийг алдах шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байна.</p>	<p>итгэлийг алдах шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргаагүй. Байгууллагын 2018 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан батлаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжийг сурталчлах үүднээс дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: - 01 дүгээр сарын 22-ны өдөр байгууллагын Эрх бүхий албан тушаалтан ХАСХОМ-ын сургалтыг зохион байгуулсан, - 02 дугаар сарын 28-ны өдөр Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбогдуулан хууль зөрчигчдөд хэрхэн хариуцлага тооцох, мэдээ тайлан, хавтаст хэрэг үүсгэх эрх, зүйн баримт бичгийн талаар Нийслэлийн Прокурорын газраас прокурор н.Мэндсайхан, н.Ганцэцэг нар сургалт зохион байгуулсан. - 06 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газраас Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албаны сахилга хариуцлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, удирдах ажилтны ёс зүй, манлайлал сэдэвт сургалт зохион байгуулсан. - Хүчийн төгөлдөр мөрдөж буй Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай харьцуулсан сургалтыг 08 дугаар сарын 17-нд, Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх сургалтыг 09 дүгээр сарын 25-ны өдөр албан хаагчдад зохион байгуулсан.</p>
1.15	<p>Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажиллана.</p>	<p>Энэ онд 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас Хүлээгдэж буй гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны нийт зардал 1.200.089 тэрбум төгрөг үүнээс: - Цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд 914.848.000 төгрөг, - Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 110.259.000 төгрөг - Байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд 48.200.000 төгрөг, - Хангамж бараа материалын зардалд 60.674.000 төгрөг, - Норматив зардалд 3,014,910 төгрөг, - Эд хогшил худалдан авах зардалд 772,200 төгрөг, - Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 37.958,548 төгрөг, - Бараа үйлчилгээний бусад зардалд 24.363.000 төгрөгийн зардлыг тус тус хууль тогтоомжийн дагуу зардлын ангиллаар захиран зарцуулж, хяналт тавьж ажиллаж байна. Нийслэлийн төсөвт тусгагдсан төлөвлөгөөний дагуу тайлант онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 870,0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 163,9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажиллахаас үндсэн үйл ажиллагааны орлого 903,2 сая төгрөг туслах үйл ажиллагааны орлого 142,6 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 101.2 хувиар биелүүлсэн. Байгууллагын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын цахим www.http://transport.ub.gov.mn/ хуудсанд байрлуулсан. НТЭГ-ын 2018 оны баталсан төсөв, нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих ахмад</p>

		настан, цагдаа, сурагч, оюутны унааны зардлын 2018 оны нөхөн олговрын төсөв, 2018 оны 1-12 сарын хуваарилалт, төсвийн гүйцэтгэлийн тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.
1.16	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлын хариуцан ажиллана.	НТЭГ-ын даргын 2018 оны А/17 дугаар тушаалаар "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын дагуу шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулах албан тушаалтнуудын хуваарь батлагдсан. Уг хуваарийн дагуу шилэн дансны www.shilendans.gov.mn , www.ub-procurement.mn сайтад мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулан ажиллаж байна. НТЭГ-ын 2018 оны баталсан төсөв, нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих ахмад настан, цагдаа, сурагч, оюутны унааны зардлын 2018 оны нөхөн олговрын төсөв, 2018 оны 1-12 сарын хуваарилалт, төсвийн гүйцэтгэлийн тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.
1.17	Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.	Байгууллагын өмч, хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах тал дээр гэрээний биелэлтийн дагуу гүйцэтгэлийн үр дүнг хариуцан ажиллаж байна.
1.18	Нийслэлийн байгууллагуудад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй www.edoc.ub.gov.mn болон иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх, шүүхэд хянан хэлэлцэгдэж буй хэргүүдийн явцын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглагдаж байгаа www.smartcity.mn цахим хуудсыг хөтлөх	1. Иргэдийн санал гомдлыг 24 цагаар утсаар хүлээн авах ажлыг зохион байгуулсан. 11 сарын байдлаар тухайлсан тээврийн хэрэгсэл болон жолоочтой холбоотой 3436, шугамын үйлчилгээтэй холбоотой санал 972 санал хүлээн авч ТТХэлтэс, ТХХэлтэс, ЗТҮХэлтэс, УБСК ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдэд шилжүүлж иргэдэд хариу мэдэгдсэн. Гомдлыг төрлөөр нь авч үзвэл: жолооч, шалгагчийн зан харьцаатай холбоотой-517, замын хөдөлгөөний аюулгүй байдал зөрчсөн-588, цагийн хуваарь баримтлаагүй-368, стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр үйлчилсэн-154, чиглэл зөрчсөн-19, автобусны зогсоол дээр зогсоогүй-567, үнэ тарифтай холбоотой-237, цэвэрлэгээ өнгө үзэмж-32, зогсоолын нэр зарлаагүй-2, үйлчилгээтэй холбоотой бусад гомдол-421, шугамын үйлчилгээтэй холбоотой-531. Гомдлын барагдуулалтыг үзвэл: Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн-989, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн-973, гомдол гаргагчийн буруу-293, байгууллага сахилгын арга хэмжээ авсан 565, холбогдох боломжгүй-59, гомдлын мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн-8, шугамын үйлчилгээтэй гомдлыг шалгаж, барагдуулсан -485, шийдвэрлээгүй-64. 2. Өргөдөл гомдлын нийслэлийн нэгдсэн програмд 2018 оны 12 дугаар сарын 07-ны байдлаар байгууллагад нийт 666 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 649 өргөдөл, гомдлыг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн буюу дундажаар 97,5 хувийн биелэлттэй байна. Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлоос хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 7 өргөдөл, гомдол, шийдвэрлэх шатанд 10 өргөдөл, гомдол байна. Өргөдөл, гомдлын тайланг II, III улирлын байдлаар гарган 06 дугаар сарын 29-ны өдрийн 1/869, 10 дугаар сарын 05-ны өдрийн 1/1265 тоот албан бичгүүдээр НЗДТГ-ын НҮНТөвд хүргүүлсэн болно.

1.19	Эрхлэх асуудлын хүрээнд шүүхэд үүссэн маргаанд Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох бөгөөд үүсэх аливаа үр дагаварыг Засаг даргын өмнө бүрэн хариуцана.	<p>Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай маргаантай асуудлуудад байгууллагын төлөөллийг хэрэгжүүлэх үүднээс Нийслэлийн Засаг даргыг төлөөлөн 2 шүүх хуралд ажилласан. Үүнд:</p> <p>1. Иргэн Х.Галмандахын тус газарт гаргасан зохиогчийн эрх зөрчигдсөн талаарх гомдолтой танилцаад “Нийтийн зорчигч тээврийн ажил үйлчилгээг зах зээлийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх оновчтой менежмент, зохистой хувилбар” судалгааны бүтээлийн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д заасан онцгой эрхийг тус газар нь зөрчөөгүй тайлбарыг Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын Оюуны өмчийн хяналтын газарт гаргасан бөгөөд одоогоор мэдээлэл ирээгүй болно.</p> <p>2. Бөхөг түргэн ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид нийслэлийн Засаг даргын 2016 оны А/520 дугаар “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааний талаар” захирамжийн 1 дэх хэсгийн заалтыг илт хууль бус болохыг тодорхойлох нэхэмжлэлийн шаардлагатай холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр анхан болон давж заалдах шатны шүүхэд төлөөлөн оролцож, 2018 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр Захиргааны хэргийн хяналтын шатны шүүх буюу Улсын дээд шүүхэд гомдлын дагуу төлөөлөн оролцож нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ.</p>
1.20	Үр дүнгийн гэрээний биелэлтийг “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу хагас, бүтэн жилээр Нийслэлийн Засаг даргын асуудал хариуцсан орлогчид тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс ирүүлэх бөгөөд үр дүнгийн гэрээний биелэлт, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцана.	НТЭГ-ын үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг 2018 оны эхний хагас жилийн байдлаар гарган 06 дугаар сарын 29-ний өдрийн 1/836 дугаар албан бичгийн хавсралтаар НЗДТГ-ын ХШҮХэлтэст хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар гарган хүргүүлэхэд бэлэн болсон.

Тайлан бичсэн:

Төсвийн шууд захирагч

НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГА Д.ОТГОНБААТАР

.....
(огноо)

Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН

.....
(огноо)

